



Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗАР**

ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН СУДАЛГАА

Улаанбаатар хот 2019 он

АГУУЛГА

Нэг. Ерөнхий зүйл	3
1.1 Өмнөх үг	3
Хоёр. Гадаад орчин.....	4
2.1 Дэлхийн чиг хандлага	4
2.2 Дэлхийн даяар хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн жагсаалт	7
2.3. Иргэний нисэхийн салбарт хэрэгжүүлэх боломжтой төсөл, хөтөлбөрийн жагсаалт ..	7
2.4 Иргэний нисэхийн салбарт хэрэгжүүлж буй гадаадын төсөл, хөтөлбөр	
Гурав. Эрх, зүйн орчин	
3.1 Хууль, эрх зүйн хүчин зүйл.....	
3.2 Үндэсний урт хугацааны бодлогын баримт бичиг	
3.3 Дунд хугацааны хөтөлбөр	
3.4 Богино хугацааны хөтөлбөр	
Дөрөв. Салбарт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн судалгаа	
4.1 Монгол Улсад хэрэгжүүлж байсан төсөл, хөтөлбөр.....	
4.2 ИНЕГ-т хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн судалгаа	
4.2.1. Хөтөлбөрийн жагсаалт	
4.2.1.1. ЗГ болон ЗТХЯ-наас батлагдсан хөтөлбөр	
4.2.1.2. ИНЕГ-аас батлагдсан хөтөлбөр	
4.2.1.3 Боловсруулж буй хөтөлбөр	
4.3 Жагсаалт ангилах	
4.3.1. Боловсруулж батлуулах шаардлагатай хөтөлбөр.....	
4.3.2. Хэрэгжүүлэх шаардлагатай төслүүд	
4.3.3. Хэрэгжүүлэх шаардлагатай төслүүд	Error! Bookmark not defined.

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1 ӨМНӨХ ҮГ

“Энэхүү судалгааны зорилго нь Иргэний нисэхийн салбарт хэрэгжиж байгаа болон хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсөл, хөтөлбөрүүдийг эрэмблэх, өнөөгийн нөхцөл байдалд шинжилгээ хийсний үндсэн дээр дэлхий хөгжлийн чиг хандлага, эдийн засаг болон бусад салбарын хөгжилтэй уялдуулан хөгжлийн ирээдүйн төлөвийг тодорхойлоход оршино.”

Богино хугацаанд хувьсан өөрчлөгдөж буй технологийн эрин үед улс орнууд дэлхийн чиг хандлага, өөрийн орны онцлогт тохируулан салбартаа дунд болон урт хугацааны хөгжлийн бодлого, төсөл, хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсний үр дүнд уг салбар хурдацтайгаар хөгжсөөр байна.

Манай орны хувьд УИХ-ын 2013 оны 18 дугаар тогтоолоор “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-ын баримт бичгийг анх удаа баталсан явдал нь салбарыг тогтвортой хөгжүүлэхэд томоохон хөшүүрэг болсон. Уг бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн хугацаа 2020 оноор дуусгавар болж байгаа тул цаашид дунд болон урт хугацаанд салбарт баримтлах бодлогыг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх зорилгоор энэхүү судалгааг боловсруулав.

Хөтөлбөр гэдэг нь бодлогын зорилгыг хангахад чиглэсэн өөр хоорондоо уялдаа бүхий багц үйл ажиллагааг хэлнэ.

Төсөл гэдэг нь тодорхой хэрэгцээ шаардлага, судалгаанд тулгуурлаж тодорхой цаг хугацаанд хийгдэх, нөөцийг ашиглан, гарах үр дүнг урьдчилан тооцсон, үр шимийг хүртэгсдэд чиглэсэн, хөрөнгө, хүч шаардах, хэрэгжүүлэх арга зүй бүхий төлөвлөгөөтэй, асуудлыг шийдсэнээр өөрчлөлт авчрах хамтын үйл ажиллагааны дүнд бий болох цогт үйл явцийг хэлнэ.

ХОЁР. ГАДААД ОРЧИН

2.1 ДЭЛХИЙН ЧИГ ХАНДЛАГА

2.1.1. Агаарын навигацийн чиг хандлага

Олон Улсын иргэний нисэхийн байгууллагаас гаргасан Дэлхийн агаарын навигаци 2016-2030 урт хугацааны стратеги төлөвлөгөөнд аюулгүй ажиллагаа, агаарын навигацийн багтаамж, үр ашиг, аюулгүй байдал, үйл ажиллагааг хөнгөвчлөх, агаарын тээврийн эдийн засгийн хөгжил, хүрээлэн буй орчныг хамгаалах зэрэг 5 стратеги зорилт тусгагджээ.

Ерөнхий төлөвлөгөө буюу GANP нь 15 жилийн стратегийг агуулсан байдаг бөгөөд өнөөгийн технологийг хөшүүрэгдэн, улс орнуудын баталсан үйл ажиллагааны зорилтууд дээр үндэслэсэн ирээдүйн хөгжлийг таамаглалыг гаргадаг. Block Upgrade буюу тодорхой бүтцийг сайжруулах тогтолцоо нь 2013 оноос эхлэн 2028 он болон түүнээс цааш үйл ажиллагааны төлөвлөгөө, 5 жил тутам тайлан гаргахаар зохион байгуулагддаг. Уг тогтолцоо нь стратегийн тогтвортой хөрөнгө оруулалтыг дэмжих, гишүүн улс орнууд, тоног төхөөрөмж үйлдвэрлэгчид, агаарын тээвэрлэгчид, нисэхийн үйлчилгээний байгууллагуудын зорилтыг тусгана.

Нисэхийн салбарыг үе шаттайгаар нэгдсэн нэг системээр хэсэгчлэн сайжруулах аргачлал (ASBU) нь 2016 оны батлагдсан загвараар цаг хугацааны хувьд 6 жилийн үе шаттайгаар дараах үндсэн дөрвөн салбарт бүтцийн хувьд задарч байгаа юм. Үүнд:

1. Нисэх Буудлын үйл ажиллагаа (Airport Operations);
2. Дэлхийг хамарсан харилцан зохицон ажиллах нэгдсэн систем болон өгөгдөл (Globally Interoperable Systems and Data Through Globally Interoperable System-Wide Information Management);
3. Оновчтой шийдэл болон уян хатан нислэг (Optimum Capacity and Flexible Flights);
4. Үр ашигтай нислэгийн зам (Efficient Flight Path);

Дээрх салбар тус бүр нь цаг хугацааны хэрэгжилтийн хувьд дөрвөн үе шаттай байх бөгөөд үе шат болгон дотор өөр хоорондоо харилцан хамааралтай уялдаж хэрэгжих боломжтой модулиуд байна.

ОУИНБ-аас аюулгүй ажиллагааг тогтмол дээшлүүлэх, агаарын навигацийн шинэчлэлийг үргэлжлүүлэхэд хоёр талбарт өсөлт бий болгох стратегийг боловсруулсан. Ингэснээр гишүүн орнууд, үндсэн оролцогч талууд аюулгүй ажиллагааг хангах, тогтвортой өсөлтийг бий болгох, үр ашгийг нэмэгдүүлэх, дэлхийн дахинаа шаардаж байгаа хүрээлэн буй орчинд ээлтэй, хариуцлагатай үйл ажиллагаа эрхлэн явуулах боломж олгох юм. Энэ нь нисэхийн салбарын дараагийн 10 жилийн гол сорилт байх болно.

Зарим улс орнууд Aireon-ний сансарын ADS-B-г шинээр нэвтрүүлж байгаа ба энэ нь аюулгүй ажиллагааг сайжруулж, үр ашиг, таамаглах чадамжийг дээшлүүлэн, багтаамжийг дээшлүүлж зардал хэмнэх боломжтой болно.

Aireon-ны систем нь аюулгүй ажиллагаа, үр ашигтай байдал, тоног төхөрөмжийн бэлэн байдал, гүйцэтгэлд чиглэсэн тулд агаарын навигацийн үйлчилгээний байгууллагууд зайлшгүй тавигдах ёстой төхөөрөмж гэж үзсэн. Сансарын ADS-B нь одоогийн ажиглалтын системд нэмэлт байдлаар суурилуулагдах ба ингэснээр АНБ-ыг одоогийн ажиглалтын системийн дэд бүтцийг оновчтой болгож, зардал хэмнэж, найдвартай ажиллагааг сайжруулна. Мөн Aireon-ны сансарын ADS-B систем нь ажиглалтын систем доголдох, ажиглалтаас гарах үед ажиглалтын нөөц системээр ашиглагдана.

Мөн техник, технологийн өнөөгийн хөгжил, дэвшлийг дагаад нисэгчгүй агаарын хөлгийн хэрэглээ асар их нэмэгдэж Нисэгчгүй агаарын хөлгийн системийн хөдөлгөөний удирдлага (Unmanned Aircraft System Traffic Management) зэрэг шинэ ойлголт гарчээ.

2012 онд ОУИНБ Дэлхийн хэмжээнд уялдан ажиллах НХМ-ийн систем (Globally Interoperable Air Traffic Management System) -ийн үе шатыг эхлүүлэх зорилгоор Агаарын навигацийн бага хурлыг санаачилж, зохион байгуулсан. Энэ систем нь Нисэхийн системийг хэсэгчлэн сайжруулах (Aviation System Block Upgrade) концепцид үндэслэх юм. НСХС аргачлал нь аюулгүй ажиллагааг сайжруулах, ирээдүйд бий болох нислэгийн хөдөлгөөний

хангах, хүлэмжийн хийн ялгарлыг багасгахад чиглэгдсэн олон тооны хэсэг, модульд суурилан уян хатан, загварчилсан сайжруулах арга зам болно.

Дэлхийн агаарын навигацийн салбар нь Засгийн газрын шууд хяналт дор байдаг тээврийн салбараас илүү өрсөлдөөнтэй, либералчлагдсан орчин руу шилжиж байна¹. Агаарын навигацийн салбар нь олон жилийн турш байгууллагын шинэ бүтцэд дасан зохицох асуудал, аюулгүй ажиллагаа, үйл ажиллагаа, техникийн болон хүрээлэн буй орчин, эдийн шаардлагуудтай тулгарч байв.

Дэлхийн хэмжээний НХМ-ийн гүйцэтгэлийг өөрчлөх, хориг, хязгаарлалт үгүй, үр дүнтэй аюулгүй агаарын зайг дэлхийн хэмжээнд бий болгох зорилгоор 2013 оны 2 сард Испанийн нийслэл Мадрид хотноо CANSO-ийн Гүйцэтгэх захирлуудын бага хурлаас Vision 2020-ийг боловсруулах шийдвэр гарч, гишүүн улс орнуудын бүрэн оролцоотойгоор, нээлттэй, ил тод байдлын үндсэн дээр CANSO-ийн байнгын хороод, ажлын хэсэг, CANSO-ийн бүсийн захирлууд, CANSO-ийн Ерөнхий захирал, нарийн бичгийн дарга нарын газраас батлан гаргажээ. Vision 2020-нд дэлхийн, бүс нутгийн хэмжээнд хэрэгжих нийт 126 үйл ажиллагаа орсон бөгөөд үндсэн гурван элементээс бүрдэнэ. Үүнд:

1. Нягт хамтын ажиллагаа;
2. Үнэ цэнийг бий болгох;
3. Үр дүнтэй, ашигтай зохион байгуулалт;

CANSO-ийн агаарын навигацийн үйлчилгээний ирээдүйн Global Vision нь салбарын хөдөлгөгч хүчин зүйлс, салбарын өөрчлөлтийг чиглэлийг тодорхойлж, өөрчлөлтөд саад болох хийгээд дэмжлэг үзүүлэх хүчин зүйлсийг гаргасан.

Дэлхийн нийтийн агаарын навигацийн чиг хандлага нь агаарын навигацийн үйлчилгээ, үйл ажиллагааг жигд болгох, ногоон НХМ, уян хатан агаарын зай, чөлөөт маршрутыг бий болгох, агаарын навигацийн үйлчилгээний үйл ажиллагааны зардлыг багасгах явдал юм.

Түүнчлэн дэлхийн хэмжээнд уялдан ажиллах НХМ-ийн систем (Globally Interoperable Air Traffic Management System)-ийг хөгжүүлэх, АНУБ-ыг орчин үеийн, гүйцэтгэлд тулгуурласан байгууллага болгох буюу хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад тулгуурласан бизнес удирдлагын хэлбэрээр удирдах чиг хандлагатай байна.

2020 он болон 2022 он хүртэлх Монгол Улсын чиглэл тус бүрийн өнгөрөлтийн нислэгийн зорчигчдын тоон төсөөллийг ОУАТХ-ноос гаргаснаас үзэхэд 2022 он гэхэд ирээдүйн Монгол Улсын агаарын замаар дамжин өнгөрөх агаарын хөлгийн жилийн өсөлтийн нийлмэл түвшин 4.9% болж, 140688-д хүрнэ.

2.1.2. Нисэх буудлын чиг хандлага

Агаарын тээвэрлэгчид зорчигчдын аяллын сэтгэгдлийг “эзэмшдэг” идэвхтэй, инновацийг санаачлагч түнш байсан бол нисэх буудал одоо эн тэцүү түнш болж байна. Нисэх буудал нь зорчигчдын аяллын чанарт мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг гэдгийг ойлгосноор үйл ажиллагааны хэлбэрээ өөрчилж, бизнесийн зарчмаар түлхүү ажиллах болсон.

Агаарын тээвэр либералчлагдахын хирээр “hub and spoke” системийн хүрээ тэлж, агаарын тээвэрлэгчдийн эвслийн ач холбогдол нэмэгдэн, Европ, Ази болон Ойрхи Дорнодод трансфер зорчигчийн төлөөх өрсөлдөөн эвсэлд нэгдсэн агаарын тээвэрлэгчид дунд эрчимжсэн. Ялангуяа Ойрхи Дорнодод трансфер зорчигчдод тулгуурласан зангилаа төв нисэх буудлын шинэ бизнес загвар үүсч бий болсон. Эдгээр нисэх буудлын нийт зорчигчдын ихээхэн хувийг зангилаа агаарын тээвэрлэгчдийн трансфер зорчигч эзэлж байгаа нь энэ хандлага үр ашигтай гэдгийг харуулж байгаа бөгөөд 2018 оны байдлаар зангилаа /HUB/ нисэх онгоцны буудлын үйл ажиллагааны салбар 133 тэрбум долларын орлого олж, сүүлийн 5 жилтэй харьцуулбал 3.4% -иар, нисэх буудлын бизнесүүдийн тоо 3.2%, ажилтнуудын тоо 3.2% -иар өссөн байна.

Ашиг, орлогод анхаарал төвлөрүүлэх нэмэгдсэнээр нисэх буудлын үйл ажиллагаа эрхлэгч байгууллагууд хувийн хэвшлийнхний нийтлэг зохион байгуулалтын бүтэц руу

¹ CANSO Vision 2020

шилжихэд хүрч байна. Жишээ нь, Санхүүгийн хэлтэс нь зөвхөн санхүү бүртгэлд анхаарал хандуулахаас илүү гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд болох хөрөнгө оруулалтын ашиг, эдийн засгийн үр ашиг гэх мэт хувьцаа эзэмшигчдэд үр өгөөж өгөх асуудалд анхаарал хандуулах нь нэмэгдсэнээр үйл ажиллагааг оновчтой болгоход болон гүйцэтгэлийн менежментэд анхаарахад түлхэц болсон. Менежментийн хэлбэр хүртэл гадаад болон дотоод асуудалдаа хувийн хэвшлийнхний сэтгэлгээг тусгаж эхэлсэн. Ялангуяа нисэх буудлын менежмент нь бизнесээ оновчтой болгох зорилгоор санхүүгийн хэмжүүр болон үйлчилгээний чанарын гүйцэтгэлийн гол үзүүлэлтийн системд илүү найдаж эхэлж байна.

Орлогын эх үүсвэрийг сайжруулах болон шинээр бий болгох нь дэлхийн нисэх буудлуудад гарч буй гол чиг хандлагуудын нэг юм. Онцгой хоолны газар, олон төрлийн жижиглэн худалдаа зэрэг үйлчилгээнүүд нь дэлхий даяарх олон нисэх буудлуудад зорчигчдын худалдан авалтыг нэмэгдүүлдэг. Агаарын тээвэрлэгчид дэлхийн хэмжээний өрсөлдөөнөөс орлогод нөлөөлөх дарамтыг мэдэрч байгаа бөгөөд зардлын дарамтыг нисэх буудлуудад шилжүүлэх арга замыг хайж эхэлсэн. Харин нисэх буудлууд дэд бүтцийн өргөтгөлийн өртөг өндөртэй төслийн санхүүжилтийг олох асуудалтай тулгарч байна. Эдгээр хоёр өрсөлдөөнт шаардлагыг тэнцвэржүүлэх цорын ганц арга нь нисэх буудлууд нисэхийн бус орлогод анхаарлаа төвлөрүүлэх явдал юм. Энэ нь дэлхийн нисэх буудлуудын орлогын гол эх үүсвэр болж байгаа бөгөөд нисэх буудлын санхүүгийн гүйцэтгэлд 70 хүртэл хувиар хувь нэмэр оруулж чадна гэж Олон улсын агаарын тээврийн холбоо тооцоолсон. (IATA, The Future of Airports, March 2012).

Технологи нь орчин үеийн амьдралын бараг бүх хэлбэрийг өөрчилсөн тул технологийн дэвшил аяллын хэлбэрийг үргэлжлүүлэн өөрчлөхөд гайхах зүйлгүй юм. Өөртөө үйлчлэх зорчигч бүртгэлийн автомат төхөөрөмж, гар утсан дээрх суугчийн талон, автоматжуулсан агаарын хөлөгт суух гарц, компьютер эсвэл ухаалаг төхөөрөмж ашиглан интернетээр нислэгт бүртгүүлэх гэх мэт дэвшилтэт шинэ технологиуд нь аль хэдийнэ зорчигч нэвтрүүлэлтийн хугацааг багасгахын зэрэгцээ нисэх буудлын ажилтнуудын зардлыг бууруулсан. Нисэх буудлын терминал болон бүтээгдэхүүн, үйлчилгээний мэдээллээр хангадаг автомат төхөөрөмж, тийз худалдан авах, тээш болон нислэгийн статус шалгах автомат төхөөрөмж, бараа бүтээгдэхүүн худалдаалах автомат төхөөрөмж, (Abdelaziz, May 2010) гар утасны өөртөө үйлчлэх аппликейшн гэх мэт нисэх буудлын дэвшилтэт технологиуд нь зорчигч нэвтрүүлэлтийн үйл явц, харилцаа холбоог уян хатан болоход туслан хэрэглэгчийн сэтгэгдэлд эерэг нөлөө үзүүлж, шинэ нэгдсэн системийг урьд нь хэзээ ч байгаагүйгээр хурдан нэвтрүүлэхэд тусалж байна. Зорчигчийн үйлчилгээний чанарыг сайжруулахаас гадна бүтэн биеийн сканнер, зорчигч нэвтрүүлэлтэд биометрикийг ашиглах /агаарын тээвэрлэгч болон нисэх буудлын технологийн SITA компани нисэх буудлуудын 77%, агаарын тээвэрлэгчдийн 71% нь дараагийн 5 жилийн хугацаанд томоохон хөтөлбөр болон судалгаа хөгжлийн ажилд биометрик мэдээллийн менежментийг ашиглахаар төлөвлөж байна гэж мэдээлсэн (Forbes Sep 29, 2018)/, тэсрэх бодис илрүүлэх, эсвэл сэтгэц-физиологийн шинжилгээний технологийг нэвтрүүлэх зэргээр нисэхийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг хамгийн сүүлийн үеийн технологийг ашиглан дараагийн түвшинд аваачиж байна.

2017 оны эхээр зорчигчдод дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий роботын талаар маш их мэдээ гарч байсан бол хамгийн нөлөө үзүүлэх нь нислэг үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд оролцох үүрэг бүхий робот байж магадгүй юм.

Japan Airport Terminal ХХК-ийн “Haneda Robotics Lab” нь энэ чиглэлд анхдагчаар тодорч, нисэх буудлын орчинд 7 роботын туршилтыг хийх гэж байна. Эдгээр роботууд нь тээш тээвэрлэхээс авахуулаад аюулгүй байдлын болзошгүй эрсдлийг тодорхойлох гэх мэт янз бүрийн үүрэг даалгавар гүйцэтгэх боломжтой.

2.1.3. Агаарын тээврийн чиг хандлага

Агаарын тээврийн салбарт 2018 онд 2.7 сая албан хаагчид ажиллаж байгаа ба агаарын тээвэрлэгч бүрт ажиллаж байгаа ажилтан дунджаар 109.000 ам.долларын нэмүү өртөг бүтээжээ.

2017 оны жилийн эцсийн байдлаар 3.8 тэрбум зорчигч агаарын тээврээр зорчсон бол 56.7 сая тонн ачааг агаараар тээвэрлэсэн бөгөөд дэлхий даяар 1400 арилжааны агаарын тээвэрлэгч (Бага өртөгтэй тээвэрлэгчид, захиалгат зэрэг багтсан) 25.000 агаарын хөлгөөр нислэг үйлдсэн байна. Нислэгийн өргөн сүлжээг бий болгон 3900 нисэх буудалд 170 гаруй аэронавигацийн үйлчилгээ үзүүлэгчид үйл ажиллагаагаа явуулж байна.

Олон улсын агаарын тээврээр зорчигчид 2018 онд 750 тэрбум ам.долларыг зарцуулсан нь өмнөх онтой харьцуулахад 15% өссөн.

Мөн Бага өртөгтэй тээвэрлэгчдийн тоо хөгжиж буй орнуудад өсч байгаа бөгөөд 2017 онд 1.2 тэрбум зорчигч бага өртөгтэй тээвэрлэгчээр зорчсон нь дэлхийн агаарын тээврээр зорчигчдын 30%-ийг эзэлж байна. Европийн холбооны орнуудын нийт агаарын тээврээр зорчигчдын 33%, Ази номхон далайн бүс нутгийн нийт зорчигчдын 31%, Хойд Америкийн зорчигчдын 26%-ийг эзэлжээ.

Зах зээлийн хүчтэй өрсөлдөөнтэй тулгарсан уламжлалт агаарын тээвэрлэгчид тийзний үнийн багцаас ачаа тээшний хураамж, суудлын сонголт зэргийг салган үйл ажиллагааны зардлыг бууруулж эхэлсэн. KPMG байгууллагын хийсэн судалгаанаас үзэхэд бага өртөгтэй агаарын тээвэрлэгчид болон уламжлалт агаарын тээвэрлэгчдийн нислэгийн зардлын нэгж боломжит суудал киллометр тутмын зөрүү 2.5-3.6 цент байна.

Бага өртөгтэй агаарын тээвэрлэгчид нэг төрлийн агаарын хөлгөөр цэгээс цэгийн хооронд ашигтай нислэгийн чиглэлүүдэд тогтмол нислэг үйлддэг бөгөөд агаарын хөлгийн ашиглалт өндөр байдгаараа давуу талтай. Уламжлалт агаарын тээвэрлэгчдийн хувьд нислэгийн сүлжээг өргөжүүлэх, брэнд болон үйлчилгээг сайжруулах зэрэгт илүүтэй анхаардаг ба үүнээс үүдэн зардал өсдөг.

Уламжлалт агаарын тээвэрлэгчдийн тив хоорондыг холбосон нислэгийн сүлжээ нь нислэгийн цагийг уртасгадаг бөгөөд агаарын хөлгийн засвар үйлчилгээний зардал, удирдлагын зардал өндөр байдаг.

Ирэх 10 жилд бага өртөгтэй агаарын тээвэрлэгчдийн зах зээлд эзлэх хувь өсөх төлөвтэй байна.

2.1.5. Мэдээллийн аюулгүй байдлын чиг хандлага

Иргэний нисэхийн хэмжээнд мэдээллийн технологийн чиг хандлага нь 4-р цахим хувьсгалыг нэвтрүүлэхэд чиглэж байна. Өөрөөр хэлбэл Big data буюу их өгөгдөл боловсруулалт, Cloud буюу үүлэн технологи мөн ERP системүүдийг нэвтрүүлэхэд чиглэж байна. Түүнээс гадна агаарын навигацийн системүүд олон улсын жишгээр IP-д суурилсан технологид шилжиж, бие даасан харилцан уяалдаагүй байдлыг халж эхлээд байна.

2.2 ДЭЛХИЙН ДАЯАР ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН ЖАГСААЛТ

/ICAO-аас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн стратегийн зорилтууд:

- Нисэхийн аюулгүй ажиллагаа
- Агаарын навигацийн үйлчилгээний чадавх болон үр дүн
- Нисэхийн аюулгүй байдал болон Хялбаршуулалт
- Эдийн засгийг хөгжүүлэх
- Хүрээлэн буй орчныг хамгаалах

2.2.1. Агаарын тээврийн чиглэлээр

ICAO-аас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд:

1. Airline Industry Retailing (AIR) projects

Цаашид хөгжиж буй дижитал ертөнцөд агаарын тээврээр үйлчлүүлэгчдийн хувь хүний санал хүсэлтийг авах, бодит мэдээлэлд тулгуурлах, үл үзэгдэх ажил гүйлгээ өссөөр байна.

Агаарын тээврийн ирээдүйн үзүүлэлт нь төлбөр болон түгээлтийн уламжлалт процессийг дижитал жижиглэн худлаа руу хэрхэн богино хугацаанд шилжүүлж чадахаас ихээхэн хамаарч байна.

AIR төсөл нь дижитал шилжилт агаарын тээврийн салбарын оролцоог дэмжих, шинэ чадавхийг бий болгоход туслах төсөл юм. Тэдгээр нь бүтээгдэхүүний уян хатан байдал, суваг хоорондын уялдаа холбоо, төлбөрийн хэлбэр, гуйвуулга зэргийг сайжруулах зорилготой.

БНХАУ-д хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүд:

2. 13-р таван жилийн төлөвлөгөө

Дэлхийн 2 дахь том эдийн засаг болох урд хөрш Хятадын иргэний нисэхийн салбарын нөхцөл байдал, тулгарч буй асуудлууд нь Ази-Номхон далайн бүсийн улс орнууд, ялангуяа Монгол Улсын иргэний нисэхийн салбарт чухал нөлөөтэй. 2017 онд батлагдсан БНХАУ-ын 13-р таван жилийн төлөвлөгөөнд Иргэний нисэхийн хөгжлийн талаар үндсэн 5 зорилт дэвшүүлсэн байна².

1. Иргэний нисэхийн тогтвортой аюулгүй ажиллагааг хангах;
2. Нисэх буудлын үндэсний хэмжээний нэгдсэн системийг бий болгох;
3. Нисэхийн үйлчилгээний чадавхийг бүрэн сайжруулах;
4. НХМ-ийн үйлчилгээний чанар, дэмжлэгийг бэхжүүлэх;
5. Шинэтгэл, инновацийг хэрэгжүүлэх замаар шилжилтийг хурдасгах³;

"13-р таван жилийн төлөвлөгөө" хөгжлийн төлөвлөгөөний дагуу агаарын навигацийн салбар бодлогын гол баримт бичиг гарсан нь Хятадын НХМ-ийг модернизацилах стратеги (Strategy for Modernizing Air Traffic Management) билээ.

"13-р таван жилийн төлөвлөгөө" хэрэгжих хугацаанд иргэний нисэхийн хөгжилд чиглэсэн хэд хэдэн зорилтуудыг тодорхойлсон. Эхний зорилт нь агаарын тээврийн нэг сая цаг нислэг тутамд ослын хувь хэмжээг 0.15-аас доош байлгах явдал юм. Хоёрдахь зорилт нь иргэний нисэхийн үндэсний эдийн засагт оруулж буй стратегийн үүрэг ролийн хувь нэмрийг байнга нэмэгдүүлж, тээврийн нэгдсэн систем дэх агаарын тээврийн хувь хэмжээг нэмэгдүүлнэ. Үүнд зорчигч эргэлт 28% хүрэх бөгөөд нийт тээврийн эргэлт, зорчигч тээвэр, ачаа, шуудан тээвэрлэлт 142 тэрбум тонн/км, зорчигч 720 сая, ачаа 8.5 сая тоннд хүрэх бөгөөд жилд 10.8%, 10.4% 6.2% -иар тус тус өснө. Гуравдахь зорилт нь иргэний нисэхийн чадавхийг цогцоор нь сайжруулах явдал юм. 260 гаруй тээврийн нисэх онгоцны буудлаас бүрдсэн нисэх буудлын сүлжээг сайтар төлөвлөж, үр ашигтай болгох болно.

Агаарын зайн багтаамжийн хязгаарлалтыг хөнгөвчилж, нислэгийн хөдөлгөөний менежментийн чадавхийг тасралтгүй бэхжүүлж, жилд 13 сая агаарын хөлгийг удирдах боломжтой болно. Дөрөв дэх зорилт нь зорчигчдод "нөхөрсөг үйлчилгээ" -ийг санал болгосноор үйлчилгээний түвшинг дээшлүүлэх, нислэгийн тогтмолжилтийг 80%-д хүргэх, үйл ажиллагааны чанарыг сайжруулах явдал юм. Тав дахь зорилт нь олон улсын дэд бүтцийг бий болгох, стандарт системийг бий болгох, үйл ажиллагааны орчинг тасралтгүй сайжруулах, үйлчилгээний салбарыг өргөтгөх замаар ерөнхий нисэхийн хөгжлийг эрчимжүүлэхэд чиглэнэ. 500 гаруй ерөнхий зориулалтын нисэх онгоцны буудал, 5 000 гаруй

ерөнхий зориулалтын агаарын хөлөгтэй болж, нийт нислэгийн цаг 2 саяд хүрнэ. Зургаа дахь зорилт бол ногоон хөгжлийг дэмжих явдал юм. Ногоон иргэний нисэхийн стандарт систем бол "Байгаль орчныг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх"-ийн тулд нөөцийг үр дүнтэй ашиглаж, жил тутмын дундаж хэрэглээ, нүүрстөрөгчийн давхар исэл ялгаруулалтыг "12-р таван жилийн төлөвлөгөө"-тэй харьцуулахад 4% -иар бууруулна.

Бусад оронд хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд

3. Consumer Protection Project CPP

Энэхүү төслийн зорилго нь :

- ❖ Агаарын тээврээр зорчигчдын эрх ашгийг хамгаалах
- ❖ Агаарын тээврээр зорчигчдын санал гомдлыг хүлээн авах, хэрхэн шуурхай шийдвэрлэх, нөхөн төлбөрийг барагдуулах салбарын нэгдсэн тогтлолцоог бүрдүүлэх
- ❖ Эрх нь зөрчигдвөл хаана хэнд хандах талаар мэдлэг олгох
- ❖ Агаарын тээврээр үйлчилүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа хийх
- ❖ Зорчигчдод үйлчлэх төвийг бий болгох, санал гомдол хүлээн авах утсыг ажиллуулах
- ❖ Салбарын яам, бусад төрийн байгууллагуудтай хамтран ажиллах
- ❖ Агаарын тээвэрлэгчид, нисэх буудлууд, бусад үйлчилгээний байгууллагуудтай хамтран ажиллах
- ❖ Олон улсын туршлага судлах

2.2.2. Агаарын навигаци болон Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний чиглэлээр

- ICAO-аас санаачлан хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдэд

1. Нислэгийн журам боловсруулалтын хөтөлбөр – Flight Procedure Program.

Тус хөтөлбөрийн зорилго нь Гишүүн улсуудыг Гүйцэтгэлд суурилсан навигацийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гишүүн улсуудын нислэгийн журам боловсруулалтын чадавхийг тогтворжуулж хөгжүүлэх ажилд туслалцаа үзүүлэх явдал юм.

Монгол Улс нь 2018-2020 онд хэрэгжих тус хөтөлбөрт албан ёсоор оролцох тухай сонирхлыг илэрхийлэн ИНЕГ-ын Дарга Л.Бямбасүрэн 2018 оны 3 дугаар сарын 27-нд хөтөлбөрийн баримт бичигт гарын үсэг зурж ОУИНБ-д хүргүүлсэн.

ОХУ-д хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүд:

1. “ОХУ-ын агаарын навигацийн системийг 2030 он хүртэл хөгжүүлэх стратеги төлөвлөгөө”

ОХУ-ын агаарын навигацийн системийг 2030 он хүртэл хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг⁴ агаарын навигацийн үйлчилгээ үзүүлэгч байгууллага болох НХМ УҮГ 2017 оны 7 сарын 19-нд өргөн барьсан байна. ОХУ-ын Засгийн газар баталсаны дараа 2018 оны 5 сараас эхлэн хэрэгжүүлэхээр тусгасан ба хэд хэдэн чухал хүрээг хамарсан. Уг төлөвлөгөөнд тусгаснаар 2025 он гэхэд ОХУ нислэгийн замыг оновчтой болгох, нислэгийн цагийг багасгах “чөлөөт зам бүхий агаарын зай”-г бий болгох, үндэсний аюулгүй байдал, нислэгийн аюулгүй ажиллагааны шаардлагыг хангахын сацуу агаарын тээвэрлэгч нарын зардлыг жилд 26

тэрбум рублиэр бууруулах, агаарын навигацийн системийн үйл ажиллагааны зардлыг жилд 25 тэрбум гаруй рублиэр багасгах зэрэг зорилтууд багтжээ. Стратегийн үндсэн чиглэл:

1. ОХУ-ын агаарын зайн ашиглалтыг сайжруулах;
2. Нислэгийн хөдөлгөөний аюулгүй ажиллагааг хангах;
3. CNS/ATM системийг сайжруулах;
4. Агаарын хөлгийн тоноглолыг сайжруулах;
5. Агаарын навигацид үйлчлэх цаг уурын системийг сайжруулах;
6. Агаарын навигацийн мэдээллийн үйлчилгээг сайжруулах;
7. Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

2. “ОХУ-ын НХУ-ын нэгдсэн системийн модернизаци” холбооны зорилтот хөтөлбөр⁵

Хөтөлбөрийн зорилго нь ОХУ-ын нисэхийн нэгдсэн менежментийн системийг сайжруулах, нисэхийн аюулгүй байдлыг сайжруулах, нисэх хүчин чадлыг сайжруулж, шинэ техник, технологийг ашиглан ОХУ-ын Агаарын навигацийн системийг бий болгож, хөгжүүлэх замаар түүний тоног төхөөрөмж, системийг сайжруулахад оршино.

Олон улсын иргэний нисэхийн байгууллагын зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгод хүрэхийн тулд дараах үүрэг даалгавруудыг гүйцэтгэхээр байна.

Үүнд: ОХУ-ын агаарын тээврийн хэтийн бүтэцийг нэвтрүүлэх, бүх хэрэглэгчдийн эрх ашгийн үүднээс ашиглах төлөвлөлтийг сайжруулах; агаарын навигацийн дэд бүтэц (тоног төхөөрөмж) -ийн шинэчлэл, техникийн шинэчлэл, агаарын тээврийн удирдлагын төвийг өргөжүүлэх;

Олон улсын иргэний нисэхийн байгууллагын үзэл баримтлалын дагуу үзүүлэлтэд суурилсан агаарын навигацийн системийг нэвтрүүлэх; Агаарын навигацийн цаг уурын мэдээлэлд дэмжлэг үзүүлэх дэвшилтэт систем, технологийг нэвтрүүлэх, Нисэх онгоцны эрэл хайгуул, аврах нэгдсэн системийн бүтцийг бий болгох, орчин үеийн авиа эрэл хайгуул, аврах цогцолбор байгуулах

3. ICAO-ын Олон улсын агаарын навигацийн төлөвлөгөө /GANP/

Олон улсын Нислэгийн Хөдөлгөөний Менежментийн системийг хөгжүүлэх /Achieving a global ATM system/

Энэ нь Олон улсын Нислэгийн хөдөлгөөний менежментийн систем (АТМ)-ийг хөгжүүлэх нь нэг төрлийн АТМ-ийн бүс нутгууд болон нислэгийн урсгал, маршрутын бүсийн бүтцийг зөв зохион байгуулахад оршино.

-Нислэгийн урсгалуудын бөөгнөрөл/ маршрутын бүсүүдийг хянах АТМ-ийн тусламжтай хянах;

-Олон улсын төлөвлөгөөний санаачилгууд:

Олон улсын төлөвлөгөөний санаачлагууд нь бүс нутгуудад гүйцэтгэлийн зорилтуудыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой юм.

Гүйцэтгэлийн зорилтуудын төлөвлөлт, хэрэгжилтийг ойрын хугацаанд хийж, хувьсан өөрчлөгдөж хөгжүүлэх зорилготой болно.

-Нэгдсэн санаачилга:

Төлөвлөлтийн үйл явцыг хөнгөвчлөхийн тулд санаачлагуудыг хэрэгжүүлнэ. Тус санаачлагууд нь хоорондоо харилцан уялдаатай байна.

- Төлөвлөлтийн үйл явцын хувьсал:

Олон улсын агаарын навигацийн төлөвлөгөө нь дэлхий даяар ATM системийг хэрэгжүүлэх төлөвлөлтийг хийхийн тулд ATM системийг боловсруулах үлгэрчилсэн ойлголт бөгөөд энэ нь цаашдын хэрэгжилтээс хүлээгдэж буй үр өгөөжийг тодотгож өгдөг.

Түүнчлэн Олон улсын ATM системийн хэрэгжүүлэх ажлуудыг төлөвлөхдөө анхаарах шаардлагатай хэд хэдэн асуудлаар ATM-ийн боловсруулж буй мэргэжилтнүүдэл зориулсан ерөнхий мэдээллийг өгдөг. Үүнд хүний нөөцийн хөгжил, сургалтын хэрэгцээ, хууль эрх зүйн асуудал, бүтэц зохион байгуулалт, олон улсын хамтын ажиллагааны асуудлууд, өртгийн ашиг шинжилгээ, эдийн засгийн нөлөөлөл, санхүүгийн асуудлууд, техникийн хамтын ажиллагаа болон олон улсын ATM-тэй холбоотой байгаль орчны ашиг тусын тухай мэдээллүүд хамаарна.

4. Европын нэг тэнгэрийн Нислэгийн хөдөлгөөний менежмент /ATM/-ийн судалгаа (SESAR)

-SESAR 2020 он хүртэлх ажлын хөтөлбөр / 2016-2019 он, 2021 цаашдын төлөв/

Single European Sky ATM Research (SESAR) нь Европын агаарын зай, түүний нислэгийн хөдөлгөөний менежментийг бүрэн шинэчилэх зорилготой хамтарсан төсөл юм. Тус хөтөлбөрийг SESAR-ны төр ба хувийн хэвшлийн түншлэл бүхий байгууллага удирддаг. Энэхүү хөтөлбөр нь дараах хүрээг хамарна. Үүнд:

- Агаарын навигацийн менежмент;
- Агаарын тээврийн үйл ажиллагаа;
- Олон улсын нисэхийн стандарт, журмыг шинэчилсэн боловсруулж, сайжруулах;
- Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний тооцоолол хийх;
- Өндөр гүйцэтгэлтэй нисэх буудлын үйл ажиллагаагаар хангах;
- Агаарын зайн хэрэглэгч буюу агаарын тээвэрлэгч болон зорчигчдыг дэлхийн түвшинд нийцсэн, харилцан уялдаатай, өндөр гүйцэтгэлтэй агаарын тээврээр хангах;
- ATM-ийн зохион байгуулалт, интеграцлал, нисэх буудлын барилгын зохион байгуулалт, үйлчилгээний нөхцөлд онцгой анхаарал хандуулах;
- Агаарын тээврийн нэгдмэл байдал, зардал болон байгаль орчинд ээлтэй байдлаах хангах;
- Европын болон олон улсын түвшинд нийцсэн стандартчилал, зохицуулалт болон харилцан уялдаатэй ажиллах боломжид дэмжлэг үзүүлэх;

5. Холбооны Нисэхийн Удирдах Байгууллага /FAA/ төсөл, хөтөлбөрийн хүрээнд:

Дараагийн үеийн агаарын тээврийн систем (Next Generation Air Transportation System- NextGen)

NextGen нь агаарын тээврийн системийг орчин үеийн болгохын тулд нислэгийг илүү аюулгүй, илүү үр ашигтай, урьдчилан таамаглах боломжтой болгох юм.

NextGen нь зөвхөн нэг технологи, бүтээгдэхүүн, зорилго биш юм. NextGen нь аюулгүй ажлын талаар нарийн шинжилгээ хийсний үр шинэлэг шинэ технологи болон

агаарын зайд зориулсан журмыг төлөвлөж хэрэгжүүлэхэд оршино. Судалгаа, инноваци, хамтын ажиллагааны хүрээнд NextGen нь дэлхийн стандартыг тогтоож, FAA-ын дэлхийн манлайлалыг нисэх онгоцны үйлдвэрт бий болгох зорилготой юм.

FAA нь NextGen-ийн технологи, журам, бодлого, хөтөлбөрийг 2025/2030 он гэхэд зорчигч, нисэхийн үйлдвэрлэл, хүрээлэн буй орчинд ашиг тустай бодлогооо дэмжин ажиллахаар төлөвлөж байна.

FAA-ын шинэчлэлийг аюулгүй ажиллагааны тест явуулсны дүнд техник технологи, инновацид суурилан боловсруулж, хэрэгжүүлдэг.

6. Шинэ Зеланд Улсын төсөл, хөтөлбөрийн хүрээнд:

Тухайн улсын Агаарын зай, Агаарын навигацийн төлөвлөгөө - Агаарын тээврийн системийг орчин үеийн болгох -/National Airspace and Air Navigation Plan-Modernising Aviation System/

Тус төлөвлөгөө нь Агаарын навигаци, Хяналт, Харилцаа холбоо, Нисэхийн мэдээлэл, Нислэгийн хөдөлгөөний менежмент, Агаарын зайн зохион байгуулал, Аэродром болон Цаг уурын үйлчилгээ зэргийг хамарсан найман бүлгээс бүрдэнэ. Төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг 2016-18, 2019-23 онуудад хэрэгжүүлнэ.

ICAO-ын Олон улсын агаарын навигацийн төлөвлөгөө /GANP/ болон ICAO-ын төлөвлөгөөг заавал биелүүлэх албагүй боловч олон улсад хэрэгжиж буй агаарын навигацийн системийг зохицуулахад зориулсан төлөвлөлтийн хэрэгсэлийг бий болгох шаардлагатай юм. Хэрэв улс орнууд агаарын болон агаарын навигацийн системийг шинэчлэх хэрэгцээ байна гэж үзвэл ICAO-ын төлөвлөгөөнд тусгагдсан холбогдох модулиудыг дагаж мөрдөх нь зүйтэй. Ази-Номхон Далайн бүсийн хөгжлийн хувьд улс орнуудад чиглэсэн, бүс нутгийн уялдаа холбоог хангах бүс нутгийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх.

7. Бүгд Найрамдах Сингапур Улсын төсөл, хөтөлбөрийн хүрээнд:

Цахим үйлчилгээ болон маягт

Нисэхийн мэдээлийн удирдлагын тогтолцоо /Aeronautical Information Management (AIM) System нь нисгэгч, агаарын тээвэрлэгчид болон бусад НМУ-ний хэрэглэгчид шинэчлэгдсэн нислэгийн мэдээллийг тухай бүр авах боломжийг олгодог бөгөөд нислэгийн төлөвлөгөөг цахимаар өгөх боломжийг олгодог байна.

Анх удаа хэрэглэх этгээд AIM Portal вэбсайтад шинээр бүртгүүлэх бөгөөд уг ажиллагааг 3 минутын дотор гүйцэтгэнэ. AIM системийн хэрэглэгч нь e-NOTAM мэдээллийг агуулсан нислэгийн үйл ажиллагаанд нөлөөлж болохуйц нислэгийн өмнөх мэдээллийг хураангуй (Pre-Flight Information bulletin-PIB)-г хүлээн авах бөгөөд түүнд:

- Аэродром
- Нислэгийн мэдээллийн бүс (FIR)
- Нислэгийн төлөвлөгөө
- NOTAM дугаарын талаарх шинэчлэгдсэн мэдээллүүд багтсан байна.

Нислэгийн төлөвлөгөөг цахимаар гарган өгөх болон боловсруулах (e-Flight Plan -FPL)

FPL нь агаарын хөлгийн таних тэмдэг, хөөрөлт, нисэн очих аэродром, нислэгийн хурд, түвшин, маршрут зэрэг мэдээллийг агуулдаг бөгөөд цахимаар мэдүүлсэн мэдээллийг бүртгэх ажиллагааг 10 минутад багтаан гүйцэтгэдэг байна.

1. **Free Email service** - Сингапур Улсын Иргэний нисэхийн ерөнхий газар нь Нисэхийн Мэдээллийн Нэгдсэн Багцад шинээр мэдээлэл орсон тохиолдолд цахим шуудангаар нь мэдээ хүргүүлдэг үйлчилгээг үзүүлдэг байна.
2. **ATLAS** – Air Transport Licensing and Administration System систем буюу цахим хуудсаар дамжуулан хуваарьт бус нислэгийн зөвшөөрлийг авах, шинэчлэх хүсэлтийг шийдвэрлэж байна.
3. **Aerial activities** - Агаарын зайд ашиглан үйлдэгдэх дараах чөлөөт үйл ажиллагаануудыг явуулахад шаардагдах зөвшөөрлийг цахимаар өгөх:
 - Агаараас зураг авах үйл ажиллагаа
 - Цаасан шувуу хөөргөх
 - Солют
 - Агаарын бөмбөлөг болон хийн дүүргэлт ашиглан хөөрөх хэрэгсэл хөөргөх
 - Гэрэлт дэнлүү хөөргөх
 - Том оврын агаарын бөмбөлөг хөөргөх
 - Лазер болон гэрлэн дэлгэц агаарт цацах
 - Хүнгүй агаарын хөлөг удирдах үйл ажиллагаа

2.2.3. Нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал

ICAO-аас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд:

1. Техникийн хамтын ажиллагааны хөтөлбөр.

Хөтөлбөрийн хүрээнд Олон Улсын Иргэний Нисэхийн Байгууллага /ICAO/ нь үндэсний болоод олон улсын иргэний нисэхийг тогтвортой хөгжүүлэх, нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдалд чиглэсэн төслүүдийг зөвлөгөөгөөр хангах ажлыг гүйцэтгэдэг.

2. Аюулгүй ажиллагааны өргөтгөсөн аудитын хөтөлбөр – USOAP

Тус хөтөлбөрийг 2010 оны 9 дүгээр сарын 28-аас 10 дугаар сарын 08-ны хугацаанд зохион байгуулагдсан ОУИНБ-ын 37 дахь удаагийн Ассамблейн хурлын А37-5 тогтоолоор “Аюулгүй ажиллагааны хяналтын өргөтгөсөн аудит хөтөлбөр”-ийг албан ёсоор хэрэгжүүлэхээр тогтсон бөгөөд уг хөтөлбөрийг байнгын хяналтын аргачлал (Continuous Monitoring Approach-БХА)-аар буюу тогтмол хэрэгжүүлж байхаар тогтсон. БХА-ын хүрээнд ICVM буюу ОУИНБ-ын Удирдамж бүхий баталгаажуулалтын ажиллагаа хамаардаг.

2010 оны 6 дугаар сарын 28-аас 7 дугаар сарын 07-ны хугацаанд Монгол Улсын Иргэний нисэхийн ерөнхий газар нь ОУИНБ-ын Аюулгүй ажиллагааны өргөтгөсөн аудитын хөтөлбөрт 87.92%-ийн үнэлгээтэйгээр хамрагдсан.

3. Иргэний нисэхийн Аюулгүй байдлын хөтөлбөр – USAP

Энэхүү хөтөлбөр нь ОУИНБ-аас хэрэгжүүлж буй Иргэний нисэхийн аюулгүй байдлын аудитын хөтөлбөр бөгөөд Монгол Улс нь Олон Улсын иргэний нисэхийн байгууллага /ICAO/-ын USAP-CMA аудитын хөтөлбөрийн хүрээнд 2015 оны 10-р сард баримт бичигт суурилсан үзлэг шалгалтад хамрагдаж амжилттай дүн үзүүлсэн болно.

Энэхүү аудитаар илэрсэн үл тохиролыг арилгах зорилгоор Залруулах ажлын төлөвлөгөөг 2016 онд, мөн 2017 онд уг төлөвлөгөөний явцын тайланг тус тус хүргүүлээд байна.

Иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангах зорилгоор манай улсын холбогдох байгууллагууд хамтран ажиллаж Чикагогийн Конвенцийн Хавралт 17 болон Хавсралт 9-ийн нисэхийн аюулгүй байдлын холбогдох шаардлагуудыг хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

4. Хойд Азийн бүсийн орнуудын Нислэгийн аюулгүй ажиллагаа болон Нислэгт тэнцэх чадварын хадгалалтын хамтын ажиллагааны хөтөлбөр (COSCAP-NA)

Тус хөтөлбөр нь 2003 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд гишүүн орнуудын /БНХАУ, БНСУ, БНАСАУ, Монгол Улс/ хамтын ажиллагааны хүрээнд ИКАО-аас тавьж буй стандарт шаардлагуудыг ижил түвшинд хангах, аюулгүй ажиллагааны нэгдсэн системийг бий болгож иргэний нисэхийн салбар дахь хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэгдсэн.

Энэхүү хөтөлбөрт манай улс оролцсоноор бид өмнөө тавьсан зорилтуудыг хэрэгжүүлэх, Хойд азийн бүсийн Төлөөлөн удирдах зөвлөлд тодорхой байр суурьтай болох, тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд өөрийн орны байр сууриа илэрхийлэх, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх зэрэг ач холбогдолтой бөгөөд дараах зорилтуудыг хэрэгжүүлэх бүрэн боломжоор хангагдах юм. Үүнд:

- хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох
- аюулгүй ажиллагааны стандартыг дээшлүүлэх, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн Ази Номхон далайн бүсийн орнуудын харилцан уялдаатай нэгдсэн дүрэм журамтай болох
- агаарын тээвэрлэгч болон агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллагад хийх аюулгүй ажиллагааны хяналтын хөтөлбөрийг боловсронгуй болгох, олон улсын стандартад нийцүүлэхэд шаардлагатай зөвлөмж авах, бусад орны мэргэжлийн хүмүүстэй хамтарсан үзлэг шалгалтыг өөрийн орны байгууллагуудад хийж гүйцэтгэх
- ИКАО-оос хэрэгжүүлж буй аюулгүй ажиллагааны аудит шалгалтын зөвлөмж, шаардлагыг бүрэн биелүүлэхэд бусад орны хамтын ажиллагаа, туслалцаа дэмжлэг авах
- Хамтарсан сургалт зохион байгуулах, мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай байцаагчдыг сургаж бэлтгэх, туршлага солилцох.

2017 онд зохион байгуулагдсан COSCAP-NA хөтөлбөрийн 17 дахь Удирдах зөвлөлийн хурлаар тус хөтөлбөрийн ач холбогдол, үр дүнг хүлээн зөвшөөрч хөтөлбөрийн IV дэх Ye шатыг 2018 оны 02 дугаар сарын 01-ээс эхлэн 5 жилийн хугацаатайгаар үргэлжлүүлэхээр тохиролцсон болно. COSCAP-NA хөтөлбөрийн Phase IV-д Хонг Конг, Макао /Hong Kong SAR, China and Macao SAR, China/ улсууд нэгдэн орж байгаа.

IATA-ноос хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд:

5. IATA Operational Safety Audit (IOSA) program

Хөтөлбөр нь агаарын тээврийн үйл ажиллагааны менежмент, хяналтын тогтолцоог үнэлэх олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээний систем юм. IOSA аудит нь дэлхий дахиныг хамарсан стандарттай харьцуулж болохуйц стандартыг бий болгож, аудитын тайлангийн хамтарсан ашиглалтыг нэмэгдүүлдэг. IOSA-ийн гишүүн агаарын тээврийн компаниудад өргөн цар хүрээтэй зардлын хэмнэлтийг бий болгосон. Энэхүү хөтөлбөрийн 15 жилийн ой тохиож байна.

6. IATA's Safety Audit for Ground Operations (ISAGO)

Уг хөтөлбөр нь дэлхий даяар бүх компаниудыг хамаарах аудитын стандартуудад тулгуурласан бөгөөд тэдгээрийн үйл ажиллагаанд хамаарах нэгдсэн стандартыг бий болгосон. Үүний үр дүнд ISAGO аудитыг үндэстэн дамнасан газрын үйлчилгээ үзүүлэгчид, мөн жижиг компаниуд ч хэрэглэж байна.

7. Global Aviation Data Management (GADM) program

IATA Аюулгүй Ажиллагааны Удирдлага ба Дүн шинжилгээний үйл ажиллагаа нь IATA-ийн Аюулгүй Байдлын стратегийн зургаан хүчин зүйлийн нэг хэсэг бөгөөд Global Aviation Data Management (GADM) хөтөлбөрөөр дамжуулан хэрэгждэг.

GADM нь IATA болон бусад салбарын эрх бүхий байгууллагууд нь олон төрлийн мэдээллийн хэрэгсэл, агаарын тээврийн үйл ажиллагаа явуулах олон төрлийн мэдээллээр хангадаг.

IATA-ийн GADM хөтөлбөрийн хүрээнд 470 гаруй байгууллагаас мэдээлэл авах боломжтой.

Их Британи Улсын Иргэний нисэхийн ерөнхий газар /UK Civil aviation authority/

8. Аюулгүй байдлын менежментийн систем (SeMS)

Их Британи Улсын Иргэний нисэхийн ерөнхий газар нь аюулгүй байдал болон чанарын үнэлгээг хийх шинэчилсэн хөтөлбөрийн хүрээнд Аюулгүй байдлын менежментийн систем (SeMS)-ийг боловсруулсан.

Аюулгүй байдлыг хангахын тулд системтэй байх нь ямар ач холбогдолтой болохыг хүн бүр мэддэг боловч аюулгүй байдалд анхаарлаа төвлөрүүлж чаддаг эсэх нь тодорхойгүй байдаг. Агаарын хөлгийг үргэлж терроризмын гол зорилтот хэрэгсэл гэж үздэг. Гэсэн хэдий ч дэлхий даяар улс орнуудын хувьд нисэхийн аюулгүй байдалд хандах хандлагын нэг том хэмжээ нь "байнга өөрчлөгдөж байгаа аюул заналхийллээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг илүү үр дүнтэй болгох юм. Иймд дээрх системээр дамжуулан аюулгүй байдлыг хангах нь чухал юм. Тулгарч буй аюул заналыг багасгахад анхаарч авч үзэх хэрэгтэй.

Үүний нэг чухал хэсэг нь тухайн байгууллага өөрийн түвшинд нисэхийн аюулгүй байдлыг хангаж ажиллах шаардлагатай бөгөөд мөн нисэхийн эрх бүхий зохицуулах байгууллага аюулгүй байдлыг хангах нь чухал асуудал юм.

2.2.4. Хүний нөөцийн чиглэлээр

ICAO-аас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд:

1. “Иргэний нисэхийн дараа үеийн мэргэжилтнүүд” – Next Generation Aviation Professionals.

Өрсөлдөх чадвартай, шаардлага хангасан иргэний нисэхийн мэргэжилтнүүд бэлтгэгдэх явдлыг баталгаажуулах, ирээдүйн олон улсын агаарын тээврийн тогтолцоог зохицуулах чадвартай иргэний нисэхийн мэргэжилтнүүдийг бэлтгэх зорилготой санаачлага юм.

2036 он гэхэд:

- 620,000 нисгэгч буюу 100-аас дээш суудалтай агаарын хөлгийн хувьд өдөрт 67 шинэ нисгэгч;
- 125,000 нислэгийн хөдөлгөөний удирдагч буюу өдөрт 13 шинэ НХУдирдагч;
- 1.3 сая агаарын хөлгийн засвар үйлчилгээний ажилтан тус тус хэрэгцээтэй болох судалгааг ICAO гаргасан байна.

2. Global Aviation Training буюу ICAO-аас олон улсын хэмжээнд зохион байгуулж буй сургалтын хөтөлбөр.

Тус хөтөлбөрийн хүрээнд:

- Нисэхийн аюулгүй байдал
- Аюултай ачаа
- Гүйцэтгэлд суурилсан навигаци
- Аюулгүй ажиллагааны удирдлага
- Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны өргөтгөсөн аудитын хөтөлбөр гэсэн чиглэлүүдээр тус тус сургалтын үйл ажиллагаа зохион байгуулж байна.

2.2.5. Байгаль орчны чиглэлээр

ICAO-аас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд:

1. Олон улсын нисэхийн үйл ажиллагаан дахь нүүрсхүчлийг тэнцвэржүүлэх ба бууруулах төлөвлөгөө – CORSIA Carbon Offsetting and Reduction Scheme For International Aviation /Annex 16 Volume 4 adopted and currently circulating/

Олон улсын хэмжээнд агаарын тээврийн үйлчилгээ үзүүлж буй ICAO-ын бүх Гишүүн улс 2019 оноос эхлэн CO2 emission буюу нүүрсхүчлийн ялгаруулалтдаа хяналт шинжилгээ хийх, тайлагнах, баталгаажуулах /ХШТБ/ үүрэгтэй. Агаарын тээвэрлэгч нь тухайн улсын эрх бүхий байгууллагын баталсан хяналт шинжилгээний аргачлалын дагуу олон улсад гүйцэтгэж буй нислэгт ашиглаж буй шатахууны хэрэглээндээ хяналт шинжилгээ хийн мэдээллийн сан үүсгэх үүрэгтэй.

Уг хөтөлбөрт хамрагдаж буй гишүүн улсын агаарын тээвэрлэгч нь шатанхуун хэрэглээний хяналт шинжилгээндээ 5 төрлийн өөр аргачлалаас сонгон хэрэглэх боломжтой.

CORSIA-г Хэрэгжүүлэх 3 шат

- Туршилтын шат 2021-2023 он
 - Эхний шат 2024-2026 он
 - Хоёр дахь шат 2027-2035 он
- Төлөвлөгөөний Туршилтын /2021-2023 он/ болон Эхний /2024-2026 он/ шатанд гишүүн улсууд сайн дурын үндсэн дээр оролцоно.

IATA-аас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд:

9. IATA Carbon Offset Program

IATA-ын 30 гаруй агаарын тээврийн компаниуд өөрсдийн борлуулалтын вэбсайт буюу гуравдагч нийлүүлэгч компанийг нэгтгэсэн програм хангамжийг нэвтрүүлсэн байна.

IATA-ийн уг хөтөлбөр нь стандартчилалын процессыг агуулдаг бөгөөд агаарын тээврийн компаниуд найдвартай, бие даасан баталгаажсан нөхөн олговрын хөтөлбөрийг хялбархан нэвтрүүлэх боломжийг олгодог.

Уг хөтөлбөр нь нүүрстөрөгчийн ялгаралыг бууруулах ажлыг зохион байгуулах, хэрэгжүүлэх шилдэг туршлагыг санал болгодог. Оффисуудыг сайтар сонгосон, бүртгэсэн бөгөөд нүүрстөрөгчийн тооцооны асуудлыг ICAO-ийн агаарын тээврийн нүүрстөрөгчийн ялгаралыг тооцох аргачлалыг ашиглан өгөгдөлд нийцүүлэх хөтөлбөр юм.

10. IATA Environmental Assessment (IEnvA)

IATA Байгаль Орчны Үнэлгээ (IEnvA) хөтөлбөр нь агаарын тээвэрлэгчдийн байгаль орчны менежментийг бие даан үнэлэх, сайжруулахад чиглэсэн үнэлгээний систем юм IEnvA нь байгаль орчны менежментийг тасралтгүй сайжруулж байх үүрэг хариуцлагын зарчмууд дээр үндэслэсэн сайн дурын хөтөлбөр юм.

11. FRED+

FRED + компани нь ICAO-ийн шаардлагуудын дагуу CORSIA нүүрстөрөгчийн ялгаруулалтын тайланг хангахын тулд сүүлийн үеийн технологиудыг боловсруулсан бөгөөд ялгарлын өгөгдөлийг аюулгүй, найдвартай дамжуулахын тулд төрийн эрх бүхий байгууллагуудтай шууд холбогддог.

Аналитик хяналтын самбар болон түлшний, ялгарал, үйл ажиллагааны үр ашгийн талаарх мэдээллээр хэрэглэгчид, агаарын тээвэрлэгчдийг хангасан суурь жишиг тайлантай танилцах боломжтой.

FRED + нь CORSIA, тэдгээрийн улсын эрх бүхий байгууллага, тодорхойлогчийн шалгуурт хамруулах бүх агаарын тээврийн операторуудад нэвтрэх боломжтой.

FRED + одоогоор бета хувилбарт байгаа бөгөөд 2019 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн CORSIA-тэй ажиллахаар төлөвлөж байна.

12. Sustainable Aviation Fuels (SAF)

Олон улсын агаарын тээврийн байгууллага IATA/-ны гишүүн агаарын тээвэрлэгчид ойрын болон дунд хугацаанд нүүрстөрөгчийн ялгаралтыг бууруулах, Алтернатив шатахууны хэрэглээг нэмэгдүүлэх богино болон дунд хугацааны зорилго тавьж байгаа ба улс орны Засгийн газраас уг зорилгыг хэрэгжүүлэхэд ихээхэн дэмжлэг үзүүлэх шаардлагатай.

Энэхүү шинэ төрлийн шатахуун нь нүүрстөрөгчийн ялгаралыг 80 хувиар бууруулж байна. Туршилтын анхны зорчигч тээврийн нислэгийг 2008 онд амжилттай хийсэн ба 2011 оноос 22 агаарын тээвэрлэгчид хуваарьт нислэг үйлдэж байна. Олон улсын агаарын тээврийн байгууллаг /IATA/ -ийн зүгээс 2020 оноос уг шатахууны хэрэглээг өсгөх, арилжааны сувгуудаар байршуулан түгээх дараах зорилтыг дэвшүүлээд байна.

- ✓ Засгийн газраас бодлогоор дэмжих
- ✓ Шатахууны өртөг зардлыг бууруулах
- ✓ Салбарын бодлогыг уг шатахууныг хөгжүүлэхэд чиглүүлэх
- ✓ Агаарын хөлгийн шатахууны найдвартай, тогтвортой хэрэглээг дэмжих

Тогтвортой алтернатив шатахууныг /Sustainable alternative fuel/ дэмжих зорилгоор олон улсын иргэний нисэхийн байгууллагууд хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, туршлага судлах, нүүрстөрөгчийн ялгаралтыг бууруулах чиглэлээр олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх ажлууд хийгдэж байна.

-Шинэ Зеландын Улсын хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд:

13. Нислэгийн хийн ялгарлыг бууруулах төлөвлөгөө /Aviation emissions reduction plan/

Шинэ Зеланд Улсын Олон улсын болон Дотоодын нислэгийн хийн ялгаруулалтыг зохицуулахад оршино.

Агаарын хөлгийн хийн ялгарлыг бууруулах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж, агаараас ялгарах утаа ялгаруулалтыг бууруулах хэд хэдэн арга хэмжээг хэрэгжүүлэх

төлөвлөгөөг тусгасан. Энэ нь Шинэ Зеландын 10 жилийн хөтөлбөр бөгөөд агаарын болон агаарын навигацын системийг шинэчлэхэд зориулагдсан юм. Шинэ Зеландын агаарын тээврийн системд 2023 он хүртэл шинэ технологийг нэвтрүүлэхэд тодорхой чиглэлийг өгч байгаа бөгөөд гол арга хэмжээ нь нислэгийн утаанаас ялгарах хийг багасгахад чиглэж байна болно. Засгийн газрын түвшинд Шинэ Зеландын Засгийн газар нийт ялгаруулалтыг зохицуулах, төрөл бүрийн салбарт хэрэгжиж буй хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

Олон улсын Агаарын Тээвэрлэгчдийн Холбоо (IATA) –ноос зорилтот түвшинд түлшний өмнөлт, нүүрстөрөгчийн ялгаруулалтын бууруулах зорилтуудыг биелүүлэх үүрэг хүлээсэн. Үүнд:

- 2010-2020 онуудад түлшний үр ашгийг жилд дунджаар 1.5%-иар сайжруула;
- 2020 оноос хойш нүүрстөрөгчийн саармагжуулалтыг нэмэгдүүлэх;
- 2005 оны түвшинтэй харьцуулахад 2050 он гэхэд хийн ялгаруулалтыг 50 хувиар бууруулна.

2.2.6. Нисэх буудлын чиглэлээр

IATA-аас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд:

1. Digital Cargo project

Цаасгүй ирээдүй:

Агаараар ачаа тээвэрлэх нь олон тооны мэдээлэл шаарддаг. Агаарын тээврийн салбарын мэдээллүүд нь ихэвчлэн цаасан дээр тулгуурладаг. Электрон процесс явагдаж байгаа үед олон дутагдалтай талууд гарсаар байна. (мэдээллийн чанар муу, хамрах хүрээ бүрэн бус, нийтлэг мэдээллийн стандарт дутагдалтай, хуучин технологи, стандартыг ашигладаг)

Төслийн алсын хараа нь цаас хэрэглэдэггүй, ухаалаг өгөгдөл хуваалцах, шинэлэг, нэмүү өртөг шингэсэн үйлчилгээг хэрэглэгчдэдээ хүргэх, үр ашигтай агаарын ачааны тээврийн салбарыг хөгжүүлэх юм.

Төсөл, санаачлагууд:

IATA нь Ачаа тээврийн үйлчилгээ & Технологийн Зөвлөл (COTB) болон түүний дэд бүлгүүдтэй агаарын ачааны стандартыг шинэчлэх, үйлдвэрлэлийн төслүүдтэй хамтран ажиллах, шинэ технологиудыг судлах, тэдгээрийн боломжит нөлөөллийг үнэлэх, агаарын ачааны нийлүүлэлтийн сүлжээнд ашиглах:

Төслүүд: e-Air Waybill, eAWB360 болон eAWBLink

Ачааны стандартууд: Cargo-XML, Piece Level Tracking гэх мэт.

Технологи: утасгүй технологи (мэдрэгч ба өгөгдлийг бүртгэгч), блокчлол, интернет зүйл, том өгөгдөл гэх мэт.

8. StB Cargo project – Ачаа тээврийн бизнесийг хялбарчлах төсөл

Ачаа тээврийн бизнесийг хялбарчлах нь (StB) Cargo бол IATA –ын ачаа дамжуулалтын хөтөлбөр юм. StB Cargo нь агаарын ачаа тээврийн ач холбогдол, шинэлэг сэтгэлгээг хөгжүүлэх шинэ санаачлага, маргаашийн агаарын ачаа тээврийн салбарын шинэ хөдөлгүүрийг бий болгох төслүүдийн багц юм.

Хуучин загварын цаасан дээр суурилсан процесс нь ил тод байдал дутмаг, тээвэрлэлтийн асуудлуудтай тулгардаг. Тиймээс агаарын тээврийн үр ашиг, үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэх явдал чухал юм.

StB Cargo-ийн 6 төсөл өнөөдрийн байдлаар хэрэгжиж байна.

1. Цахим-ачаа & e-AWB: цаасгүй болсоор байна

2. ONE Record: ухаалаг өгөгдөл хуваалцах
3. Интерактив ачаа: ачааны яриа хийх
4. Ухаалаг хэрэгсэл: ачаа зөөвөрлөх тоног төхөөрөмжийн жолоодлогын чанар, ил тод байдал
5. ACID - Агаарын ачаа тээврийн ослын өгөгдөл: өгөгдөлд тулгуурласан сайжруулах хөтөлбөр
6. Ачааны холболт: холболтыг хялбаршуулан, шинэчилж байх

9. IATA-FIATA Air Cargo Program

IATA Карго агентлагийн хөтөлбөр нь ачааны агент болон агаарын тээврийн компаниудын хоорондох бизнесийн харилцаанд нөлөөлж буй өөрчлөлтийг үл харгалзан олон арван жил үйл ажиллагаа явуулж ирсэн., IATA –FIATA нь ачаа тээврийн зуучуудын холбоо Олон улсын холбоо, Олон улсын тээвэр зууч, Логистикийн үйлчилгээ үзүүлэгч компаниудын төлөөлөл, мөн агаарын тээврийн компаниудыг нэгтгэж байна.

Үзэл баримтлал

Энэхүү хамтын ажиллагааны зорилго нь агаарын тээврийн компаниудын бага хурал дээр үндэслэсэн хөтөлбөрийг дахин хянаж, дахин инженерчлэл, нисэх онгоцны компаниуд хамтран зохион байгуулах юм. Томоохон алхмууд хийгдсэн бөгөөд энэ хамтын ажиллагаа нь шинэ хамтарсан IATA-FIATA Air Cargo хөтөлбөрийг боловсруулж, агаарын тээвэр, үүрэг хариуцлагыг дахин тодорхойлоход чухал ач холбогдолтой юм.

10. Fast Travel Program

Уг хөтөлбөр нь аялал жуулчлалын ирээдүйг илүүтэй чиглүүлэх, зорчигдод өөртөө үйлчлэх сонголтыг бий болгосноор үйлдвэрлэлийн зардлыг бууруулахад чиглэсэн.

Fast Travel хөтөлбөр нь зорчигч тээврийн аялалын зургаан бүс нутагт өөрийн үйлчилгээг үзүүлдэг бөгөөд энэ нь жилийн хуримтлалыг 2.1 тэрбум ам.долларт хүргэдэг. Нэг стандарт, зөвлөгөөг дагаж мөрдөх замаар IATA эдгээр төслүүдийг хэрэгжүүлдэг. Аялал жуулчлал, нисэх буудлууд нь Fast Travel Matchmaker-д бүртгүүлэх хүсэлтээ ирүүлсээр байна.

Fast Travel хөтөлбөрийн хэрэгжилт 2020 онд

Одоогийн байдлаар- 71.71% (2018 оны 09 сарын байдлаар)

2020 онд – 80% хүрэх төлөвлөгөөтэй байна.

2020 он гэхэд дэлхий даяарх зорчигчдын 80% нь ая тухтай байдлыг хангаж, дарааллыг багасгахын тулд аяллын туршид өөртөө үйлчлэх үйлчилгээг авах төлөвтэй байна.

11. Passenger Facilitation program

Дэлхийн агаарын тээврийн зорчигч урсгал 2037 он гэхэд 8.2 тэрбумд хүрэх төлөвтэй байна. Дараагийн 20 жилд урьдчилсан таамаглалаар жилийн өсөлтийн хурд нь 3.5% болж өнөөдрийн түвшингээс зорчигчдын тоо хоёр дахин нэмэгдэх төлөвтэй байна. Уг хөтөлбөр нь зорчигч тээврийн үйл явцын хамгийн чухал хэсгүүдэд гол анхаарлаа хандуулан "зорчигчдын аюулгүй байдал, үр дүнтэй туршлага" -ыг хангах зорилготой юм. IATA-ийн Passenger Facilitating Facilitation Program нь дараах асуудлуудыг шийдэх шийдлийг санал болгож байна.

- Цагаачлал: зорчигчдын өсөлтийг дэмжих, хүлээлтийн хугацааг багасгахын тулд аюулгүй байдлын хил хяналтыг автоматжуулах замаар хилийн гарцыг сайжруулах.
- Зорчигчдын биеийн байцаалтыг зохицуулах Нэг ID нь хувь хүн өөрийн биеийн байцаалтыг онлайнаар эсвэл биечлэн шалгах боломжийг олгодог. Энэ нь хувийн мэдээллийн нууцлалыг хадгалахын зэрэгцээ үйл явцын бүх үе шатанд шаардлагатай түвшинд хангах ёстой.

12. New Distribution Capability

NDC нь аялал жуулчлалын салбарыг чөлөөт цагаа өнгөрөөх болон бизнес аялагчдад борлуулалтын арга замыг өөрчлөх боломжийг олгодог. NDC (New Distribution Capability) нь шинэ, XML-д суурилсан өгөгдөл дамжуулах стандарт (NDC Standard) -ийг хөгжүүлэх, зах зээлийг нэвтрүүлэхэд зориулсан IATA-аас гаргасан аялал жуулчлалын салбарын дэмжлэгтэй хөтөлбөр (NDC Program) юм. NDC-ийн стандарт нь агаарын тээвэр болон аялалын агентуудын хоорондох харилцаа холбооны чадавхийг сайжруулдаг. NDC-ийн стандарт нь аливаа гуравдагч этгээд, зуучлагч, МТ үйлчилгээ эрхлэгч эсвэл IATA гишүүн бус хүмүүст нээлттэй, хэрэгжүүлж, ашиглах боломжтой юм.

13. Smart Security

Хөтөлбөр нь ойрын жилүүдэд аюулгүй байдлыг хамгаалалт хэрхэн өөрчлөгдөхийг судлах, өнөөгийн байдлаар нисэх онгоцны буудлууд дээр хэрэгжүүлж буй зарим шинэлэг санаачилгуудыг багтаасан. Аюулгүй байдлыг хангах үүднээс нөөцийг хуваарилж, нисэх буудлын байгууламжийг оновчтой байлгах асуудлыг шийдвэрлэхийг зорьсон.

14. Бүгд Найрамдах Сингапур Улсын төсөл, хөтөлбөрийн хүрээнд:

Сингапур Улсын Иргэний нисэхийн ерөнхий газар⁶ нь **Нисэхийн Хөгжлийн Сан** (НХС)-аар дамжуулан нисэхийн салбарын өсөлт, хөгжлийг дэмждэг бөгөөд (2015 оны 4-р сарын 01-ээс 2020 оны 3-р сарын 31-ний хугацаанд) 5 жилийн хугацаанд 160 сая сингапур доллар (ам.доллар 116,307,200)-ыг зарцуулахаар төлөвлөсөн. НХС нь хөгжлийн чиг үүрэг бүхий дараах салбаруудад зарцуулагдана:

- Нисэх буудлын үр бүтээлийг нэмэгдүүлэх
- Чанги Олон Улсын Нисэх Буудлын өрсөлдөх чадвар бүхий зангилаа болгон хүчирхэгжүүлэх
- Чанги ОУНБ-ыг ухаалаг үндэстний Ухаалаг гарц болгон хөгжүүлэх нь

НХС-аар дэмжин хэрэгжүүлсэн зарим амжилттай төслүүдийг дурдвал:

- **Карго тээврийн үйл ажиллагааны хяналтын систем, Dnata**

Dnata нь ачааны хөдөлгөөнийг хянах, бүртгэх зорилгоор Карго Терминал дотор тусгай камер болон тэмдэгтүүдийг суурьлуулсан. Ингэснээр ачаа алдагдсан тохиолдлыг шалгах зорилгоор шаардлагатай дүрс бичлэгийг гарган авах боломжтой болсон бөгөөд алдагдсан ачааг эрэн хайж олон ажиллагааны үр ашгийг 60%-иар нэмэгдүүлсэн.

- **Чанги ОУНБ дахь эрт бүртгэл**

Эрт бүртгэлийн үйлчилгээ (Early check-in service ECI) нь зорчигчид нислэгээсээ 24 хүртэлх цагийн өмнө бүртгэл хийлгэж болох уян хатан үйлчилгээ юм. ECI үйлчилгээг үзүүлэхийн тулд агаарын тээвэрлэгчдийг байнгын ажиллагаа бүхий бүртгэлийн цэгийг ажиллуулах шаардлага тавьдаг. Чанги ОУНБ нь терминал бүрт эрт бүртгэлийн үйлчилгээний цэгийг ажиллуулснаар хүний хүн-цагийн зардлыг 20%-иар бууруулсан байна.

- **Сингапур Эйрлайнсийн хэрэгжүүлсэн өөртөө үйлчлэх бүртгэлийн киоск**

Нисэхийн хөгжлийн сангийн санхүүжилтээр Сингапур Эйрлайнс (SIA) нь 2 болон 3-аар терминалд өөртөө үйлчлэх бүртгэлийн киоскуудыг ажиллуулсан. Үр дүнд нь зорчигч

⁶ <https://www.caas.gov.sg/about-caas/areas-of-responsibility/developing-the-industry/aviation-development-fund>

үйлчилгээний ажилтнуудын тоог бууруулж зорчигчдын дараалалд зарцуулах хугацааг бууруулсан.

2.2.7. Санхүү, эдийн засгийн чиглэлээр

IATA-аас хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд:

1. ADM Reduction Project

Энэхүү төслийн зорилго нь:

- ADM-ийн хэрэгцээг багасгахын тулд ажлын ачаалал, нөөц, цаг хугацааны орлогын аудитад зарцуулсан цаг хугацааг багасгах;
- Ажлын янз бүрийн процессыг боловсронгуй болгож, ADM процессыг сайжруулж, төлбөр тооцооны дараах төлбөр тооцооны процессыг бий болгох;
- Одоогийн байгаа ажлын урсгалын хүрээнд харилцааны үйл явцыг сайжруулах, бизнесийн харилцааг сайжруулах;
- Одоогийн хуваарилалтын гинжин хэлхээн дэх үр ашиггүй байдлыг олж илрүүлсний дараагаар ADM-ээр дамжуулан төлбөрийн дараах орлогын нөхөн төлбөрийг багасгах шаардлагатай болсон.

2. High Performing Finance Organizations (HIPO) Program

Санхүүгийн функц нь агаарын тээвэрлэгчийн санхүүгийн үйл ажиллагаа нь бизнесийн үйл ажиллагаа, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх, аж ахуйн нэгжийн эрсдлийн менежмент гэх мэт үйл ажиллагаагаар санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэгдсэн агаарын тээвэрлэгчийн итгэлтэй удирдамж болж өгдөг.

3. Operational Efficiency & Cost Management (OECM) program

Хөтөлбөр нь агаарын тээврийн компаниудад зардлын хэмнэлттэй шийдлийг олж тогтоох, хөгжүүлэх, үйл ажиллагааны ерөнхий зардлын бүтцийг сайжруулах, үйлчилгээний гүйцэтгэлийн түвшинг сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилготой.

OECM –ийн хүрээ нь нислэгийн үйл ажиллагаа, техникийн үйл ажиллагаа (агаарын хөлгийн түрээс, бүтээгдэхүүний менежмент, нийлүүлэлтийн сүлжээ), газрын үйлчилгээ, OCC-operation control center, үйл ажиллагааны төлөвлөлт зэрэгт хамаарна.

2.1 МОНГОЛ УЛСАД ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН ЖАГСААЛТ

2.3.1 Агаарын навигаци болон Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний чиглэлээр

- (Next Generation Air Transportation System- NextGen)
- UTM Unmanned Aircraft System Traffic Management
- ADS-B System

- System-Wide Information Management (SWIM)

2.3.2. Нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал

- Аюулгүй байдлын менежментийн систем (SeMS)
- Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын систем /ASOS/
- /Ухаалаг аюулгүй байдал/ Smart Security (SmartS) IATA, ACI

2.3.3. Хүний нөөцийн чиглэлээр

- “Иргэний нисэхийн дараа үеийн мэргэжилтнүүд” – Next Generation Aviation Professionals.

2.3.4. Байгаль орчны чиглэлээр

- Олон улсын нисэхийн үйл ажиллагаан дахь нүүрсхүчлийг тэнцвэржүүлэх ба бууруулах төлөвлөгөө – CORSIA /ICAO/

2.3.5. Нисэх буудлын чиглэлээр

- NEXTT IATA, ACI
- Skytrax Airport Star Ranking
- Green Airports Recognition /Ногоон нисэх буудал/ ACI
- Airport Service Quality (ASQ) Programme /Нисэх буудлын үйлчилгээний чанарын хөтөлбөр/ ACI

2.3.6. Санхүү, эдийн засгийн чиглэлээр

- ADM Reduction Project

2.3.7. Агаарын тээврийн чиглэлээр

- Consumer Protection Project CPP
- ULCC, LHLC, Hybrid LCC

2.4. МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАРТ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ГАДААДЫН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР

2.4.1. Аюулгүй ажиллагааны өргөтгөсөн аудитын хөтөлбөр – USOAP

Тус хөтөлбөрийг 2010 оны 9 дүгээр сарын 28-аас 10 дугаар сарын 08-ны хугацаанд зохион байгуулагдсан ОУИНБ-ын 37 дахь удаагийн Ассамблейн хурлын А37-5 тогтоолоор “Аюулгүй ажиллагааны хяналтын өргөтгөсөн аудит хөтөлбөр”-ийг албан ёсоор

хэрэгжүүлэхээр тогтсон бөгөөд уг хөтөлбөрийг байнгын хяналтын аргачлал (Continuous Monitoring Approach-БХА)-аар буюу тогтмол хэрэгжүүлж байхаар тогтсон. БХА-ын хүрээнд ICVM буюу ОУИНБ-ын Удирдамж бүхий баталгаажуулалтын ажиллагаа хамаардаг.

2010 оны 6 дугаар сарын 28-аас 7 дугаар сарын 07-ны хугацаанд Монгол Улсын Иргэний нисэхийн ерөнхий газар нь ОУИНБ-ын Аюулгүй ажиллагааны өргөтгөсөн аудитын хөтөлбөрт 87.92%-ийн үнэлгээтэйгээр хамрагдсан.

2.4.2. Иргэний нисэхийн Аюулгүй байдлын хөтөлбөр – USAP

Энэхүү хөтөлбөр нь ОУИНБ-аас хэрэгжүүлж буй Иргэний нисэхийн аюулгүй байдлын аудитын хөтөлбөр бөгөөд Монгол Улс нь Олон Улсын иргэний нисэхийн байгууллага /ICAO/-ын USAP-CMA аудитын хөтөлбөрийн хүрээнд 2015 оны 10-р сард баримт бичигт суурилсан үзлэг шалгалтад хамрагдаж амжилттай дүн үзүүлсэн болно.

Энэхүү аудитаар илэрсэн үл тохирлыг арилгах зорилгоор Залруулах ажлын төлөвлөгөөг 2016 онд, мөн 2017 онд уг төлөвлөгөөний явцын тайланг тус тус хүргүүлээд байна.

Иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангах зорилгоор манай улсын холбогдох байгууллагууд хамтран ажиллаж Чикагогийн Конвенцын Хавралт 17 болон Хавсралт 9-ийн нисэхийн аюулгүй байдлын холбогдох шаардлагуудыг хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2.4.3. Хойд Азийн бүсийн орнуудын Нислэгийн аюулгүй ажиллагаа болон Нислэгт тэнцэх чадварын хадгалалтын хамтын ажиллагааны хөтөлбөр (COSCAP-NA)

Тус хөтөлбөр нь 2003 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд гишүүн орнуудын /БНХАУ, БНСУ, БНАСАУ, Монгол Улс/ хамтын ажиллагааны хүрээнд ИКАО-аас тавьж буй стандарт шаардлагуудыг ижил түвшинд хангах, аюулгүй ажиллагааны нэгдсэн системийг бий болгож иргэний нисэхийн салбар дахь хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэгдсэн.

Энэхүү хөтөлбөрт манай улс оролцсоноор бид өмнөө тавьсан зорилтуудыг хэрэгжүүлэх, Хойд Азийн бүсийн Төлөөлөн удирдах зөвлөлд тодорхой байр суурьтай болох, тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд өөрийн орны байр сууриа илэрхийлэх, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх зэрэг ач холбогдолтой бөгөөд дараах зорилтуудыг хэрэгжүүлэх бүрэн боломжоор хангагдах юм. Үүнд:

- хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох
- аюулгүй ажиллагааны стандартыг дээшлүүлэх, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн Ази Номхон далайн бүсийн орнуудын харилцан уялдаатай нэгдсэн дүрэм журамтай болох
- агаарын тээвэрлэгч болон агаарын хөлгийн техник үйлчилгээний байгууллагад хийх аюулгүй ажиллагааны хяналтын хөтөлбөрийг боловсронгуй болгох, олон улсын стандартад нийцүүлэхэд шаардлагатай зөвлөмж авах, бусад орны мэргэжлийн хүмүүстэй хамтарсан үзлэг шалгалтыг өөрийн орны байгууллагуудад хийж гүйцэтгэх
- ИКАО-оос хэрэгжүүлж буй аюулгүй ажиллагааны аудит шалгалтын зөвлөмж, шаардлагыг бүрэн биелүүлэхэд бусад орны хамтын ажиллагаа, туслалцаа дэмжлэг авах
- Хамтарсан сургалт зохион байгуулах, мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай байцаагчдыг сургаж бэлтгэх, туршлага солилцох.

2017 онд зохион байгуулагдсан COSCAP-NA хөтөлбөрийн 17 дахь Удирдах зөвлөлийн хурлаар тус хөтөлбөрийн ач холбогдол, үр дүнг хүлээн зөвшөөрч хөтөлбөрийн IV дэх Ye шатыг 2018 оны 02 дугаар сарын 01-ээс эхлэн 5 жилийн хугацаатайгаар үргэлжлүүлэхээр тохиролцсон болно. COSCAP-NA хөтөлбөрийн Phase IV-д Хонг Конг, Макао /Hong Kong SAR, China and Macao SAR, China/ улсууд нэгдэн орж байгаа.

2.4.4. Нислэгийн журам боловсруулалтын хөтөлбөр – Flight Procedure Program

Тус хөтөлбөрийн зорилго нь Гишүүн улсуудыг Гүйцэтгэлд суурилсан навигацийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гишүүн улсуудын нислэгийн журам боловсруулалтын чадавхыг тогтворжуулж хөгжүүлэх ажилд туслалцаа үзүүлэх явдал юм.

Монгол Улс нь 2018-2020 онд хэрэгжих тус хөтөлбөрт албан ёсоор оролцох тухай сонирхлыг илэрхийлэн ИНЕГ-ын Дарга Л.Бямбасүрэн 2018 оны 3 дугаар сарын 27-нд хөтөлбөрийн баримт бичигт гарын үсэг зурж ОУИНБ-д хүргүүлсэн.

2.4.5. Кувейтын сангийн хөрөнгөөр Хэнтий аймаг дахь Нисэх буудлын барилга байгууламж, аэродромыг сайжруулах төсөл

Кувейтийн сангийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хамтран хэрэгжүүлэх санал тавьсны дагуу 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Хэнтий аймгийн Чингис хотод Монгол Улсын Сангийн яам, Арабын эдийн засгийн хөгжлийн Кувейтийн сангийн төлөөлөгчид, Хэнтий аймгийн Засаг дарга, Иргэний 30% нисэхийн ерөнхий газрын төлөөллүүдийн хамтарсан хурлаар “Өндөрхаан” нисэх буудлыг хөгжүүлэх төсөлд 3.500.000 /гурван сая таван зуун мянга/ ам.долларт багтаан тус төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд 2019 онд барилгын ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна.

ГУРАВ. ЭРХ, ЗҮЙН ОРЧИН

3.1. Хууль, эрх зүйн хүчин зүйл

Үндэсний урт хугацааны бодлогын баримт бичиг

1. Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал, 2011
2. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, 2016

Дунд хугацааны хөтөлбөр

1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2016-2020, 2016

Богино хугацааны хөтөлбөр

1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл

Монгол Улсын хуулиуд:

1. Иргэний нисэхийн тухай хууль, 1999
2. Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хууль, 2003
3. Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль, 2003
4. Инновацийн тухай хууль, 2012
5. Чөлөөт бүсийн тухай хууль, 2015

Улсын Их Хурлын тогтоолууд:

1. Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого, 2010
2. Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого, 2013

Засгийн газрын тогтоолууд:

1. Хөгжлийн зам үндэсний хөтөлбөр, 2017
2. Төрөөс мэдээлэл, харилцаа, холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого 2017-2025, 2017
3. “Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр”, 2018
4. “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”, 2018
5. Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр, 2018

Салбарын яамнаас баталсан хөтөлбөр:

1. Зам, тээврийн стандартчиллын тогтолцоог боловсронгуй болгох дунд хугацааны хөтөлбөр, 2013
2. Зам, тээврийн салбарт инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр, 2015
3. Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны хөтөлбөр, 2016
4. Агаарын хөлгийн шувуу, мал амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх хөтөлбөр, 2016

Одоогоор Иргэний нисэхийн салбарын хэмжээнд нийт 12 стандарт мөрдөгдөж байна.

3.2. Үндэсний урт хугацааны бодлогын баримт бичиг

1. Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал, 2011

21.3.түлш, эрчим хүч, зам, тээвэр, харилцаа холбоо зэрэг дэд бүтцийн салбарыг хөгжүүлэхэд дөхөм үзүүлэх;

21.4.олон улс, бүс нутгийн эдийн засгийн интеграц болон дэд бүтцийн сүлжээнд нэгдэхийг эрмэлзэх, далайн боомт хүрэх, дамжин өнгөрөх зам, тээврийн таатай нөхцөл бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

2. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, 2016

Зорилт 3. Эдийн засгийн өсөлтийг хангах зам, тээвэр, ложистикийн сүлжээг хөгжүүлнэ.

I үе шат (2016-2020): Замын-Үүд, Хөшигийн хөндий, Алтанбулагт тээвэр ложистикийн төв байгуулж, олон улсын болон улсын чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын уртыг 1600 км-ээр нэмэгдүүлж, Ухаа худаг–Гашуун сухайт чиглэлийн төмөр замыг барьж ашиглах, Эрдэнэт–Овоот, Богд хаан төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлэх, дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлэх.

II үе шат (2021-2025): Хөдөө аж ахуй, аж үйлдвэр, уул уурхайн салбарт түшиглэсэн тээвэр ложистикийн төвүүдийг барьж ашиглалтад оруулах, тээврийн шинэ төрлүүдийг хөгжүүлэх, улсын чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын уртыг 800 км-ээр нэмэгдүүлж, Эрдэнэт–Овоот, Богд хаан төмөр замыг барьж дуусгах, бүсүүдийн төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлэх.

Зорилт 4. Хэрэглэгчийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн, эдийн засгийн үр ашигтай, аюулгүй, ая тухтай тээврийн үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлнэ.

I үе шат (2016-2020): Гадаад, дотоод худалдааны тээврийн зардлыг бууруулах, хугацааг багасгах, аймаг болон томоохон сумдын нисэх буудлыг хөгжүүлэх, ерөнхий зориулалтын агаарын тээврийг хөгжүүлэх, Хөшигийн хөндийн олон улсын нисэх буудлыг барьж дуусгах.

II үе шат (2021-2025): Гадаад, дотоод худалдааны тээврийн зардлыг бууруулах, хугацааг багасгах, үндэсний нисэхийн нөөц буудал байгуулах, агаарын тээвэрт чөлөөт өрсөлдөөнийг дэмжиж, Хөшигийн хөндийн нисэх буудлыг бүс нутгийн зангилаа төв болгон хөгжүүлэх, орчин үеийн технологид тулгуурласан нийтийн тээврийн шинэ тогтолцоог Улаанбаатар хотод бий болгох.

III үе шат (2026-2030): Гадаад, дотоод худалдааны тээврийн зардлыг бууруулах, хугацааг багасгах, үндэсний агаарын тээврийн сүлжээг хөгжүүлж, бүс нутагт агаарын тээврийн транзит төвийг хөгжүүлэх.

3.3. Дунд хугацааны хөтөлбөр

2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2016-2020, 2016

2.117.Үндэсний болон олон улсын тээвэр, ложистикийн сүлжээг хөгжүүлж, “Хөшиг”-ийн хөндийд холимог тээвэр ложистикийн төв байгуулна.

2.118.Төрөөс агаарын тээврийн салбарт баримтлах бодлогод тулгуурлан орон нутгийн болон олон улсын нислэгийн тоог нэмэгдүүлэх, өрсөлдөөнийг дэмжих замаар тус салбарт үнэ тарифыг бууруулна.

2.119.Жижиг нисэх онгоц, нисдэг тэрэгний зах зээлийг хөгжүүлж, гамшгаас хамгаалах, хүнс, хөдөө аж ахуй, эрүүл мэндийн түргэн тусламжийн үйлчилгээ, иргэний агаарын тээвэр, аялал жуулчлалын чиглэлээр ашиглана.

2.220.Тээврийн салбарын олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлж, бүс нутгийн дэд бүтэц, тээврийн интеграцид нэгдэн орох замаар дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлнэ.

Шинжлэх ухааны удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн боловсронгуй болгож, үр дүнд суурилсан санхүүжилтийн системийг нэвтрүүлж, мэдлэгт суурилсан инноваци, технологи, үйлдвэрлэлийг хөгжүүлж, шинжлэх ухааны үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлнэ.

3.4. Богино хугацааны хөтөлбөр

2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл

Зорилт 6. Бодит салбарын өсөлтийг дэмжих, зам, тээврийн бодлого хэрэгжүүлж, ложистикийн сүлжээг өргөжүүлнэ.

Худалдааг хөнгөвчлөх тээвэр, ложистикийн төв байгуулах ажлыг үргэлжлүүлэх (МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 3-4, ЗГҮАХ-ийн 2.113 дахь заалт)

- Хөшигийн хөндийн тээвэр, ложистикийн төв байгуулах

Иргэний нисэхийн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх (МУТХҮБ-2030-ын 2.1.5, Зорилт 4, ЗГҮАХ-ийн 2.114 дэх заалт)

- Хэнтий аймгийн нисэх буудлыг өргөтгөн шинэчлэх

Монгол Улсын хуулиуд:

6. Иргэний нисэхийн тухай хууль, 1999
7. Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хууль, 2003
8. Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль, 2003
9. Инновацийн тухай хууль, 2012
10. Чөлөөт бүсийн тухай хууль, 2015

Улсын Их Хурлын тогтоолууд:

3. Төрөөс өндөр технологийн аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого, 2010
4. Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого, 2013

Засгийн газрын тогтоолууд:

6. Хөгжлийн зам үндэсний хөтөлбөр, 2017
7. Төрөөс мэдээлэл, харилцаа, холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого 2017-2025, 2017
8. “Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр”, 2018
9. “Гурван тулгуурт хөгжлийн бодлого”, 2018
10. Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр, 2018

Салбарын яамнаас баталсан хөтөлбөр:

5. Зам, тээврийн стандартчиллын тогтолцоог боловсронгуй болгох дунд хугацааны хөтөлбөр, 2013
6. Зам, тээврийн салбарт инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр, 2015
7. Иргэний нисэхийн аюулгүй ажиллагааны хөтөлбөр, 2016
8. Агаарын хөлгийн шувуу, мал амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх хөтөлбөр, 2016

Одоогоор Иргэний нисэхийн салбарын хэмжээнд нийт 12 стандарт мөрдөгдөж байна.

**ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ НИСЭХИЙН САЛБАРТ
ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН
СУДАЛГАА**

4.1. Монгол Улсад хэрэгжүүлж байсан төсөл, хөтөлбөрүүдийн талаар

- Азийн хөгжлийн банк

3. National Air Navigation Development Project / 1995.09.05 /
Loan /US\$ 23.70 million/
4. Phase II Institutional Strengthening of the Civil Aviation Sector /1995.09.05 /
Technical Assistance /US\$ 592.00 million/
5. Ulaanbaatar Airport Feasibility Study /1992.01.03 /
Technical Assistance / US\$ 600.00 million/

4.2. Иргэний нисэхийн ерөнхий газарт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн судалгаа

Иргэний нисэхийн ерөнхий газар 2010 оноос хойш хэрэгжиж байгаа, хэрэгжиж дууссан Үндэсний хэмжээний хөтөлбөр, төслүүдийн нэгдсэн судалгаанд дараах материал, эх сурвалжийг ашигласан болно. Үүнд:

1. УИХ, ЗГ-аас баталсан төсөл хөтөлбөрийн жагсаалт,
2. Зам, тээврийн хөгжлийн яамнаас баталсан төсөл, хөтөлбөрийн жагсаалт,
3. Иргэний нисэхийн ерөнхий газар болон харьяа алба салбараас боловсруулж, батлуулсан төсөл, хөтөлбөр,
4. www.legalinfo.mn вэбсайтын мэдээллийн сан.

2018 оны 08 дүгээр сарын 21-ний байдлаар Монгол Улсын Их Хурал, Засгийн Газар, Зам, тээврийн хөгжлийн яам болон Иргэний нисэхийн ерөнхий газар нийт 30 төсөл, хөтөлбөр тус тус хэрэгжүүлж байна.

Хүснэгт 1. ХӨТӨЛБӨРҮҮД

Дд	ХӨТӨЛБӨР	Хэрэгжиж байгаа	Хэрэгжиж дууссан	Хүчингүй болсон	Бусад	Нийт
1.	АНБЗГ	1	0	0	1	2
2.	АТБТГ	0	0	0	1	1
3.	ЗУГ	4	1	0	1	6
4.	ХЭЗДБГ	0	0	0	0	0
5.	СХОГ	0	0	0	1	1
6.	НААХЗА	1	-	-	-	1
7.	ТХХ	1	0	0	0	1
8.	НБУГ	3	0	0	1	4
	НИЙТ	10	1	0	5	16

Хүснэгт 2. ТӨСЛҮҮД

	ТӨСӨЛ	Хэрэгжиж байгаа	Хэрэгжиж дууссан	Хүчингүй болсон	Бусад	Нийт
1.	АНБЗГ	5	1	0	0	6
2.	АТБТГ	0	0	0	0	0
3.	ЗУГ	0	0	0	0	0

4.	ХЭЗДБГ	0	0	0	0	0
5.	СХОГ	0	0	0	0	0
6.	НААХЗА	-	-	-	-	-
7.	ТХХ	0	0	0	0	0
8.	НБУГ	4	0	0	4	8
НИЙТ		9	1	0	4	14

Хөтөлбөрийн дэлгэрэнгүй жагсаалтыг Хавсралт 1-ээс, төслийн дэлгэрэнгүй жагсаалтыг Хавсралт 2-оос үзнэ үү. Төслүүдийн жагсаалтыг зөвхөн харьяа газар, хэлтэс, албадын бэлтгэж ирүүлсэн мэдээллийн дагуу гаргасан болно. Нислэгийн аюулгүй ажиллагаа, хяналт зохицуулалтын газраас албан бичгийн хариу ирүүлээгүй болно.

Хүснэгт 3. Хөтөлбөрийг баталсан этгээдээр ангилах нь

Батлагдсан хөтөлбөрүүд	Нийт тоо	Эзлэх хувь
УИХ-с баталсан	0	0
Засгийн газраас баталсан	4	30%
Яамнаас баталсан	3	30%
ИНЕГ-аас боловсруулсан, баталсан	4	40%
Боловсруулж байгаа хөтөлбөр	6	0%
Нийт	16	100%

4.2.1. Хөтөлбөрүүдийн жагсаалт:

4.2.1.1. Засгийн газар болон Зам, тээврийн хөгжлийн яамны баталсан хөтөлбөрүүд:

- ✓ Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөрийн /НБУГ/
- ✓ Иргэний нисэхийн аюулгүй байдлын үндэсний хөтөлбөрийн /НБУГ/
- ✓ Агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээний хөтөлбөр /АТБТГ/
- ✓ Ерөнхий зориулалтын нисэхийг хөгжүүлэх хөтөлбөр /ТХХ, ЕЗНХА/
- ✓ Нисэхийн аюулгүй ажиллагааны хөтөлбөр /НААХЗА/
- ✓ Агаарын хөлөг шувуу, мал амьтантай мөргөлдөх аюулаас сэргийлэх үндэсний хөтөлбөр /НБУГ/
- ✓ Иргэний нисэхийн ерөнхий газрын стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр /ЗУГ/

4.2.1.2. Иргэний нисэхийн ерөнхий газраас батлагдсан хөтөлбөрүүд:

- ✓ “Трэйндэйр ПЛАС” хөтөлбөр /ЗУГ, НСТ/
- ✓ Иргэний нисэхийн хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр /ЗУГ/
- ✓ Нисэхийн мэдээллийн үйлчилгээнээс /AIS/ нисэхийн мэдээллийн менежментэд шилжих хөтөлбөр /АНБЗГ, НМҮА/
- ✓ Иргэний нисэхийн дараа үеийн хүний нөөцийн талаар нисэхийн сургалтын төвөөс баримтлах бодлого /ЗУГ, НСТ/

4.2.2. Төслүүдийн жагсаалт:

- ✓ УБХОУШНБ-ын менежмент төсөл
- ✓ Хэнтий аймаг дахь Нисэх буудлын барилга байгууламж, аэродромын шинэчлэх төсөл
- ✓ Ховд аймаг дахь нисэх буудлыг хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл
- ✓ Өмнөговь аймаг дахь нисэх буудлыг олон улсын нөөц нисэх буудал болгох төсөл
- ✓ Дорнод аймаг дахь нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл
- ✓ Хөвсгөл аймгийн мөрөн нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл

- ✓ Баянхонгор аймгийн Баянхонгор нисэх буудлын аэродромын хүчитгэх.
- ✓ Баян-Өлгий аймгийн Өлгий нисэх буудлын зорчигч үйлчилгээний барилгыг өргөтгөх ажил
- ✓ Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал ашиглалтад орохтой холбогдуулан “Буянт-Ухаа” нисэх буудлыг цаашид ашиглах
- ✓ Систем даяарх мэдээллийн менежмент(SWIM) хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулж SWIM хэрэгжүүлэх төсөл /system wide information management/
- ✓ Бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагад ашиглагдаж байгаа метрийн нэгжийг фүүтийн нэгжид шилжүүлэх төсөл
- ✓ Шинэ бүсийн нислэгийн хөдөлгөөний удирдлагын төв
- ✓ Агаарын зайн зохион байгуулалтыг боловсронгуй болгох
- ✓ Алсын удирдлагатай аэродромын нислэгийн хөдөлгөөний удирдлага

4.3. Жагсаалтыг ангилах

4.3.1. Боловсруулж, батлуулах шаардлагатай хөтөлбөрийн жагсаалт:

1. Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр NGAP / ТИНСББ -2020-ын 8.1.1, 8.1.2, 8.1.3/
2. Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр
3. Иргэний нисэхийн ерөнхий газрын даатгалын эрсдэлийн хөтөлбөр
4. Иргэний нисэхийн нийтлэг үйлчилгээг тодорхойлж, хувийн хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар дэмжих хөтөлбөр /ТИНСББ-2020 1.2.11./
5. Нисэх буудлуудыг 2025 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр / /ТИНСББ -2020-ын 2.2.2.6 /

4.3.2. Хэрэгжүүлэх шаардлагатай төслийн жагсаалт

1. Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал ашиглалтад орохтой холбогдуулан “Буянт-Ухаа” нисэх буудлыг цаашид ашиглах /ТИНСББ -2020-ын 6.1.7/
2. Ховд аймаг дахь нисэх буудлыг хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл /ЗГҮАХХАХТ-2.114.10/
3. Өмнөговь аймаг дахь нисэх буудлыг олон улсын нөөц нисэх буудал болгох төсөл ЗГҮАХХАХТ-2.114.11/

4.3.3. Хэрэгжиж дууссан хөтөлбөр

1. Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр /2013-2016/

4.4. Хэрэгжих боломжгүй төсөл, хөтөлбөрийн жагсаалт

- 1 Шалгалтын нислэгийн агаарын хөлөг /Төсөл/
- 2 Шалгалтын нислэгийн автомат систем АТ-940